

Өнгөрсөн жилийнхээс бага зэрэг сэрүүн зун болно

Олон жилийн дунджаас 0.5-1 хэм дулаан байх төлөвтэй. >4

Сэргэлт заасан эхний онош

Гадаад худалдааны ашиг өнгөрсөн улиралд хоёр дахин өссөн байна. >11

Ямар зардлыг танах эсэх нь Засгийн газрын өөрийнх нь асуудал

Хөгжиж буй орны эдийн засаг удаан хугацаанд тогтмол өсөх нь чухал. >12



NATIONAL NEWS CORP | БҮРЭГДЭХҮҮН КОМПАНИ

ZASAG.CO

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.04.12, ЛХАГВА ~ №067 (613)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

УИХ-ын даргад ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг өргөн барив.
Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

ГХ-ны сайд Солонгосын талтай виз хүсэгчдэд тавих шаардлагыг хөнгөвчлөхөөр тохиролцов.

НББСШУ-ны байнгын хороонохон төсвийн тодотголын хоёр дахь хэлэлцүүлгийг хийлээ.

ЭДИЙН ЗАСАГ

Хөрөнгийн биржийн индекс 843.38 нэгж болж, 0.52 хувиар өсөв.

Дэлхийн зах зээлд алтны ханш гурван өдөр дараалан өсөөд байна.

Дорнод аймагт нэг килограмм ноолуурын үнэ 100 мянган төгрөгт хүрэв.

Бүртгүүлсэн ажил хайгч иргэд энэ оны гуравдугаар сарын байдлаар 47.6 мянга боллоо.

Хугацаа хэтэрсэн зээл хоёрдугаар сард 1.052 их наяд төгрөгийг давав.

НИЙГЭМ

Хүүхдийн мөнгийг зорилтот бүлгийнхэнд олгохоор 187.2 тэрбум төгрөг хэмээнэжээ.

Үүлэнд нөлөөлж, зориудаар бороо оруулахад 420 сая төгрөг зарцуула.

Дэлхий дахинд жилд 313 сая, Монголд 400 гаруй хүн үйлдвэрлэлийн осолд өртөж байна.

Аялал жуулчлалын өрсөлдөх чадвараар 136 улсаас 102-т нь Монгол бичигджээ.

Таван толгой дахь Зэвсэгт хүчний сургалтын төвд бөмбөг дэлбэрч хоёр цэрэг амиа алдла.

ДЭЛХИЙ

Япон үстөрөгчид тулгуурласан эдийн засаг хөгжүүлэхээр төлөвлөж байна.

Дэлхийд цаазын ял гүйцэтгэсэн тоо 2016 онд жилийн өмнөхөөс 37 хувиар буурлаа.

Порокенко Донецк, Луганскийн БНУ-аас олборлодог нүүрсийг хураах саналтай.

ОХУ-ын байлдааны флот Өмнөд Солонгосын Пусан боомтод орж ирлээ.

The New York Times сонинд Пулитцерийн шагнал олгов.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.04.12



15° | -4°

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРЭНГҮЙ МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС ҮНШИНЭ ҮҮ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Ангасан хотын зовлон



Хатаж ангасан хөрс багахан салхи дэгдэх төдийд л шороогоор тургиж, “уураа гаргана”. Тэднийг услах ёстой атал хатааж тарчлаасан болохоор уурлахаас ч яахав. ▶3

Б.Ганбаяр /ЗГМ©

ЗГМ: СЭДЭВ

Ядарсан улсын арчаагүй цамаархал

Г.Сайнзаяа @sainzayaZGM

Хэдхэн жилийн өмнө “Шил авна” гэх цангинасан хоолой өдөрт хэдэнтээ сонсогддог байв. Гэвч аажмаар замхарч, ойролцоох шил авах цэгт тушааж байсан билээ. Харамсалтай нь бид энэ сайн үйлийг удаан

үргэлжлүүлж чадаагүй. Зарим нь дахин ашиглаж, зарим нь шууд хаяж байхад яахаа ч мэдэхгүй, магадгүй “Шил авна” гэдэг үг хүлээсээр угаалтуурын доор, тагтан дээрээ хадгалсаар байв. Хүнсний бүтээгдэхүүний шилэн савны нэг ч үйлдвэргүй улс атлаа хаядаг гэхээр цамаан байгаа биз. Бас хог боловсруулах үйлдвэр ч байхгүй. Ландфилл

гэх хэмжээ хязгаартай аргад л найдаж байгаа улс, бид ШУТИС-ийн Механик инженерийн сургуулийн М.Дашдэмбэрэл, С.Баяржаргал нар 2014 онд Барилгын болон шилэн сав суулганы үйлдвэр байгуулах судалгаа хийжээ.

▶5



Шинэ Дели татвараа хойшлууллаа

Киран Стэйси

Үеэ өнгөрөөсөн мужийн татварыг Энэтхэг даяар ижил үйлчлэх GST буюу бараа, үйлчилгээний татвараар солих лоббийг тус улсын бизнесийн бүлгийнхэн эртнээс өрнүүлсэн. Гэвч хүнд сурталт тогтолцоо, төгөлдөржиж амжаагүй татварын шинэ тогтолцоог нэвтрүүлэх

бэлтгэл муутай хэвээр. Иймд шинэ татвар хэрэгжүүлэхийг төлөвлөсөн хугацаанаас хойшлуулахыг бизнес эрхлэгчид уриалах болов.

“Долдугаар сарын нэгэн бодит байдалд үл нийцэх хэт өвдрөг тооцоо” хэмээн аудитийн KPMG India компанийн түнш Харприт Син үзэж байна. “Үйлдвэрлэлийн салбарт бэлтгэл хийх гуравхан сарын хугацаа гаргаж байгаа

нь дэндүү бага” хэмээн тэрбээр тайлбарласан юм.

Гэр ахуйн тавилгын Lohasmith онлайн дэлгүүр ажиллуулдаг Карун, Мена Малик нар Энэтхэгийн бизнес эрхлэгчдийн адил 29 мужид үнээ шинэчлэх, ханган нийлүүлэгчидтэйгээ тохиролцохоор завгүй ажиллаж байна.

▶9

ЗАЛУУС

Гэр бүлээ ирээдүйд гэр хороололд амьдруулахгүй

Есдүгээр ангиасаа хойш гэрийнх-нээсээ мөнгө авдаггүй болсон

Б.Бямбасүрэн @byambaZGM

“Модель Э.Оюунбилэг байна. Би байдаг л нэг энгийн охин. Сургуулиа төгсөөд бусдын адил ажил хийж байна. Саяхан болж өнгөрсөн “Mongolia's next top model” тэмцээнд оролцож, багагүй амжилт гаргалаа. Одоо надад тэс өөр ертөнцөд ирсэн юм шиг санагдаж байгаа” хэмээснээр бидний ярилцлага эхлэв.

Зөвхөн ням гарагт л амрах завтай болдог шаргуу, чадварлаг бүсгүйтэй уулзахаар


тавдугаар сургуулийн урд талд байрлах кофе шопыг зорилго. Түүний амралтын өдөр учир үсээ сүлжиж, нүүрээ хөнгөн будаж, биеийн тамцын хувцас өмссөн байлаа. Ширээн дээр мөстэй кофе, зүсэм бялуутай байх бөгөөд Л.Сарантуяагийн “Тавилан” романыг шимтэн уншиж байв. Үүнийг нь хараад амралтынх нь ганц өдрөөс “хумсалж” байгаа мэт санагдсанаа нуух юун.

Гэсэн хэдий ч хэзээний цэнхэр дэлгэцээр даруу төлөв, хэрсүү гэдгээ баталсан тэрбээр биднийг түвэгшээснэгүй харин ч инээсээр угтсан юм. Кофе шоп хэтэрхий олон хүнтэй байсан учир олигтой ярилцаж чадах болов уу хэмээн эргэлзэж суусныг нуух юун. Гэсэн ч нэг л мэдэхэд халуун дотно яриа хөвөрч, орчин тойрныг үл анзаарсан юм.

▶7

ЗГМ: ИНФОГРАФИК

ХҮН ХОНОГТ ХЭДЭН ЦАГ УНТАХ ЁСТОЙ ВЭ



ХҮНИЙ ӨДӨРТ УНТАХ ЦАГ

National sleep foundation©

MSE ALL

843.38
0.52%

АЛТ

1256.60
0.18%

ЗЭС

5747
1.49%

10-ЧИНГИС БОНД

94.790
0.04%

5-ЧИНГИС БОНД

99.980
0.04%

АМ.ДОЛЛАР

2419.66

ЮАНЬ

350.56

РУБЛЬ

42.54

Улс төр

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Төр 500 тэрбум төгрөг хэмнэх боломжтой

Төрийн албыг цомхон бүрдүүлснээр хагас их наяд төгрөг хэмнэх боломжтой

Б.Даваагтох
@datoZGM

Монгол Улсын Засгийн газрын ОУВС-тай хийсэн хэлэлцээрт гарын үсэг зурж, албажуулах ажил 2017 оны төсвийн тодотголоос хамаарч байгаа юм. Энэхүү хүрээнд ОУВС-гаас тавьсан шаардлагыг тусгаж, Засгийн газар 2017 оны төсвийн тодотголыг боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлж буй. Засгийн газар 2017 оны төсвийн тодотголыг боловсруулахдаа Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого зургаан их наяд төгрөг буюу ДНБ-ий 23.1 хувь, зарлага 8.7 их наяд буюу ДНБ-ий 33.7 хувь байхаар тооцсон юм.

Тэгвэл УИХ-ын гишүүн З.Нарантуяа, Ж.Батзандан нар төсвийн тодотголтой холбогдуулан хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Ажил олгогч эздийн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон бизнес эрхлэгчдийн төлөөлүүд оролцож.

МҮХАУТ-ын ерөнхийлөгч Б.Лхагважав “Нэгдүгээрт, бид төрийн захиргааны албан хаагчдыг 20 хувиар, төрийн үйлчилгээний албан хаагчдыг 10 хувиар танах асуудал тавьж байна. Зөвхөн эдний цалингийн зардал, урамшууллаас 500-600 тэрбум төгрөг хэмнэх боломжтой. Сүүлийн 12 жил Засгийн газар хамтарч бий болох явцдаа бүх намын төлөөллийг яам, тамбун газарт тэнцүү оруулах зорилгоор нэмсэн. Зөвхөн 2012 оноос хойш төрийн албыг 24 мянгаар нэмсэн байдаг. 2006 оноос хойш төрийн ажлын



Б.Ганбаяр / ЗГМФ

байр 60 мянга болж нэмэгдсэн. Одоо төр орон тоогоо 15-20 хувиар танахад ямар ч асуудал байхгүй. Хоёрдугаарт, төсвийн тодотголд төр зардлаа 220 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байгаа. Энэ зардлыг 2017 оны баталсан төсвийн хэмжээнд барих хэрэгтэй. Гуравдугаарт, тэтгэврийн насны асуудал

бус, тэр ч бүү хэл компанийн дундаж наслалт 10 жил. Тийм учраас төр 183 мянган иргэнийхээ асуудлыг өөрсдөө шийд. Харин тэтгэврийн насны асуудлаар чөлөөт зах зээлийн тоглогчидтой тохиролцоо ёстой” хэмээн байр сууриа илэрхийлэв. Өөрөөр хэлбэл, цомхон, чадварлаг төрийн албыг бүрдүүлснээр хагас их наяд төгрөг хэмнэх боломжтой гэж үзжээ.

Харин “Хүртэмжтэй хөгжил хүрээлэн” ТББ-ын тэргүүн Н.Туяа “Засгийн газраас 2017 оны төсвийн тодотголыг оруулж ирэхдээ иргэдийн нуруун дээр ихэнх ачааг үүрүүлж байгаад маш их бухимдалтай байна. Төсвийн бодлого дан ганц төсвийн орлого бүрдүүлдэг хэрэгсэл биш. Энэ нь нийгмийн баялгийн хэв маяг хуваарилалтыг хийдэг санхүүгийн маш том хэрэгсэл байдаг. Ингээд үзвэл энэ төсөлд ерөөсөө судалгаагүй, зүгээр л төсвийн орлого дутаг

байгаа учраас хамгийн амархан олох арга буюу татваруудыг нэмж оруулж ирж байна. Олон улсын түвшинд татварын бодлого нь эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн, нийгмийн баялгийг тэгш шударга зарцуулсан байдаг. Тэдний жишгийг харвал хөгжсөн орнуудын төсвийн 20-60 хувь нь газар буюу байгалийн баялгаасаа орж ирдэг. Нэг ёсондоо ард түмний өмч ард түмэндээ эргэн зарцуулагддаг. Тухайлбал, Австрали улс нийт төсвийнхөө 39 хувийг, Канад 38 хувийг, Испани 23 хувь, Болгар улс 20 хувийг газраас олддог. Манай улсын хувьд хөдөлмөрлөж байгаа хэсгээс олж татвар авч, төсвийн орлогын 80 гаруй хувиа бүрдүүлдэг. Төсвийн орлого өнөөдөр зургаан их наяд байгаа ч газраас олж татвар орлого нь 68 тэрбум буюу нэг хувь байна. Бид нийтийн өмчөөс олох ёстой орлогыг 20-30 дахин бага авч байгаа. Өнөөдөр манай төсвийн

бодлого нийтийн өмчийг цөөнх нь маш хямд үнээр, өрсөлдөөнгүй давуу эрхээр эзэмшиж, хөдөлмөр эрхэлж байгаа хэсгээс орлогоо бүрдүүлж, эдийн засгаа туйлдуулж байна” гэлээ.

“БСБ Сервис” компанийн захирал Б.Жаргалсайхан Хувь хүний орлогын албан татварыг шатлалтай болгож байгааг эсэргүүцэв. Тэрбээр “1.5 сая төгрөгөөс дээш орлоготой ажилтнууд нийт цалин авдаг хүмүүсийн найман хувь нь. Найман хувийн татварыг өсгөөд төсөвт дорвитой орлого орж ирэхгүй. Татварын хувь хэмжээг нэмэх юм бол олон байгууллага орлогоо нуун дарагдуулдаг хэлбэр рүү орно шүү дээ. Эцсийн эцэст хувь хэмжээг нэмж байгаа боловч нийт татвар нэмэгдэхгүй сөрөг үр дагавар гарч магадгүй” хэмээв.

Хэлэлцүүлгээ гарсан саналыг УИХ, Засгийн газар, Сангийн сайдад хүргүүлнэ гэдгээ З.Нарантуяа гишүүн тодотгов. [ЗГМ]

Хэлэлцүүлгээс гарсан саналыг УИХ болон Засгийн газарт хүргүүлнэ

байгаа. Төрд ажиллаж байгаа 183 мянган иргэний ажлын байр баталгаатай байдаг. Чөлөөт хөдөлмөрийн зах зээлд нэг сая гаруй хүн ажиллаж байгаа. Эдгээрийн ажлын байр тодорхой

ЭШЛЭЛ



“Бид Монголын улс төрийн түүхэнд анх удаа бүх гишүүдийнхээ саналаар намын даргаа сонгож чадлаа. Намын бүх гишүүдийнхээ оролцоотойгоор ардчилсан зарчмаар Дотоод сонгуулиа ч амжилттай явуулсан. Бид шинэчлэлийн салхийг эхлүүлснээр өнөөдөр бүх шатандаа шинэчлэгдэж, элдэв фракц, улстөрийн бүлэглэлийн савраас бүрэн чөлөөлөгдсөн. Бид өнөөдөр бодлогын, шинэчлэлийн нам болсон. Ардчилсан нам өнөөдөр санхүүгийн ил тод байдалд бүрэн шилжсэн гэдгийг дуулгахдаа таатай байна. Ийнхүү нэгдэж, шинэчлэгдсэн Ардчилсан нам Ардчилсан ерөнхийлөгчийн буухнагаа таслалгүй үргэлжлүүлэх ёстой. Үүний тулд бид эв эвийг эрхэмлэж, атгасан гар шиг цул хүчин болох ёстой.

Ардчилсан намын дарга
С.Эрдэнэ



“Үндсэн хуулийг өөрчлөх нь зүйтэй гэдэг байр суурьтай байсан. Одоо ч тийм байгаа. Миний энэ бодол улам илүү гүнзгийрч байна. Гэхдээ Үндсэн хуульд ойр зуурын аахар, шаахар өөрчлөлт оруулаад өнгөрөх хэрэггүй гэж боддог. Одоо бол томоохон өөрчлөлт хийх хэрэгтэй. Би хэдэн жилийн өмнө Ерөнхийлөгчийн засаглалтай байх нь зүйтэй гэж боддог байсан. Парламентын засаглал 26 жил явлаа, өөрийнхөө бодит боломжийг шахчихлаа. Цаашид ийм байдлаар Монгол Улс замнахгүй юм байна гэж боддог байсан. Тэр бодол маань цаг үеэ дагаад өөрчлөгдөж байна. Одоо надад ямар бодол төрж байна вэ гэхээр хяналттай парламенттай болох ёстой. Магадгүй хоёр шатлалтай парламент байж болох юм.

УИХ-ын гишүүн
Ө.Энхтүвшин

БҮЛЭГ

УИХ-ын гишүүд оффшорын эсрэг бүлэг байгууллаа

Б.Тогтох
ЗГМ

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж буй. Уг хуулийн төсөлд төрийн өндөр албан тушаалтан, алба хаагчдыг оффшор данстай байхыг хориглохоор тусгаад байгаа юм. Уг заалттай холбогдуулан УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан, Ц.Даваасүрэн, Х.Болорчулуун нарын гишүүн оффшорын эсрэг

лоббист бүлэг байгуулжээ.

УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан “Түр хороог УИХ-ын тогтоолоор баталдаг. Бид тогтоолоо өргөн бариад албан ёсоор явна. Оффшорын эсрэг тэмцэл гэдэг өөрөө нам харгалзалгүй, бүх нийтийн тэмцэл байх ёстой. Өнөөдрийн хямралын сэдэв хуулийн хамааралд оруулж байгаа. Ийм данстай хүмүүс гурван сарын дотор мэдүүлж байж, улс төрийн сонгуульд өрсөлдөх боломж нь нээгдэнэ. АТГ-аас холбогдох асуудлаар хяналт тавиад явах боломжтой. Гол нь, ийм хууль батлах учиртай. Оффшор бүсэд

одоогоор Монголоос хэчнээн хэмжээний доллар байгаа нь мэдэгдэхгүй байна. Үүнийг бид цаашид нягтлах болно. Оффшорын асуудлаар нэгдэж байгаа иргэний нийгмийн байгууллагуудтай тодорхой байдал холбогдож ажиллана” гэлээ.

Улс орнуудаас оффшор бүсэд нийт 21-32 их наяд ам.доллар хадгалагдаж байгаа гэсэн судалгааг олон улсын байгууллагууд гаргасан байна. Түүнчлэн 5-10 их наяд ам.долларын үл хөдлөх хөрөнгө, алт, усан онгоц, уран зураг байгаа аж. Хөгжиж байгаа улс орнууд оффшор дахь байгаа мөнгөө илрүүлж, хуулийн дагуу татвар авахад л гадаад өрнөөсөө бүрэн салах боломжтой гэсэн судалгаа бий гэдгийг лоббист бүлгийн гишүүд мэдээлсэн юм. [ЗГМ]

БАЙНГЫН ХОРОО

Засгийн газрын гишүүд концесс хариуцна

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Концессийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийв. Төсөлд яам бүр концессын гэрээгээр хийх ажлын саналаа Сангийн яаманд хүргүүлж, зөвшөөрөл олговол ажил нь эхэлдэг байхаар заасан аж. УИХ-ын Эдийн засгийн байнгын

хорооны дарга Д.Тэрбишдагва “Засгийн газрын өргөн мэдүүлсэн төслөөр сайд бүр концессын ажил хэрэгжүүлдэг болоод эхэлбэл замбараагүй болно. Ерөнхий сайдын харьяанд байх Үндэсний бодлогын хороо концессыг хариуцаад явах ёстой. Ингэж байж, цэгцэрнэ. Ийм учраас Концессын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг

буцаах ёстой” гэв.

Харин УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар “Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаавал Олон улсын валютын сантай тохирсон хөтөлбөр хэрэгжихэд хүндрэлтэй болно. Ийм учраас хуулийг хэлэлцэх шатанд асуудлыг шийдээд явах боломжийг эрэлхийлэх ёстой” гэлээ. [ЗГМ]

ТОВЧХОН

» ТӨСӨЛ

Засгийн газраас Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг өргөн мэдүүлэв. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн таван бодлого, 22 зорилт, 158 арга хэмжээний биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 61.2 хувьтай гарчээ.

УИХ-ын нэр бүхий гишүүд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг өргөн мэдүүлээ. Төсөлд Хүүхэд, хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг боловсруулан батлуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээг сайжруулах чиглэлийн асуудлуудыг нэгтгэн тусгажээ.

» ХУРАЛ

“Монгол Улсын аюулгүй байдлын орчин-Батлан хамгаалах бодлого” сэдэвт эрдэм шинжилгээний хурал боллоо. Аюулгүй байдлын орчин өөрчлөгдөж байгаагаар холбогдуулан Монгол Улсын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогод тулгамдаж байгаа асуудал болон суугаа Элчин шийдвэрлэх арга замыг эрдэмтэн, судлаачдын дунд хэлэлцүүлж, хурлаас гарах үр дүн, санал, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэхээр уг хурлыг зохион байгуулжээ.

» УУЛЗАЛТ

Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд У.Сунгтай уулзаж, хоёр улсын хооронд харилцан визгүй зорчдог байсан иргэдэд олон удаагийн виз олгох нөхцөлийг ярилцлаа. Уулзалтаар сүүлийн хоёр жилийн хугацаанд дөрөв, эсхүл нийт 10 удаа хилээр нэвтэрсэн хоёр талын иргэдэд таван жилийн хугацаатай олон удаагийн визийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох талаар тохиролцоонд хүрэв.

» ТОО

200

Сая төгрөг. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулгыг энэ сарын 29, 30-нд Төрийн ордонд зохион байгуулахаар болсон. Уг санал асуулгыг зохион байгуулахад төгрөг зарцуулахаар төсөвт суулгажээ. Санал асуулгад нийт 750 хүнийг түүврийн аргаар сонгон оролцуулах болжээ.

» АТГ

Авлигатай тэмцэх газар өнгөрсөн долоо хоногт нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 175 иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг шинээр хүлээн авчээ. Нийт 606 урьдчилсан мэдүүлгийг хянан шалгасан байна.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонин мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» OPED@ZASAG.CO

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Нийтлэлчийн булан

Ангасан хотын иргэдэд хур бороо л сүүлийн найдвар болох шинжтэй

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

Цээж хорсгосон гашуун утаа холдож, цэвэр агаараар амьсгалах урин цаг ирлээ. Өвлийн хэдэн сарын турш утаанд хордсон хотын иргэд одоо л уужим амьсгаа авахтайгаа болов. Гэвч баярлах эрт байна. Нийслэлчүүдийн зовлон ямар дуусах биш. Хэдийгээр утаа холдон олдсон ч тоос, шорооны улирал айсуу. Өвлийн нүүрсний утаа нүдэнд ил харагддаг болохоор аюулыг нь хүн бүр мэддэг. Тэр хэрээр утааны эсрэг тэмцэж, төр засагт шаардлага хүргүүлдэг билээ. Гэвч тоос, шорооны зовлонг барагтай л бол ярихгүй. Гэтэл энэ нь хор хөнөөлөөрөө утаанаас ч их байдаг аж.

Тухайлбал, тоосонд 150 төрлийн химийн хорт бодис агуулагддаг байна. Үүнд янз бүрийн бичил биетээс гадна хар тугалга, мөнгөн ус зэрэг хорт бодис ч бий. Товчхондоо бол их хотын иргэд бид өвөлдөө нүүрсний угаарт, зундаа тоос, шороонд нэрвэгдсээр аж төрж сууна.

Уг нь хавар, зуны тоос, шороог бууруулах нь өвлийн утаатай тэмцэхээс хавьгүй амар. Гудамж талбай бүрээ цэцэрлэгжүүлж, бусад хэсгээ асфальтаар хучихад болоод явчихна. Энэ бүгдийг хийхэд хөрөнгө мөнгө хүрэлцэхгүй гэсэн зовлон өөдөөс тоочил л байх. Тэгвэл ядаж тоос босгоод байгаа газраа хангалттай услаад өгөхсөн. Хэрэв яаж хийхээ мэдэхгүй бол бусад хот асуудлаа яаж шийдсэн туршлагаас судла л даа.

Узбекистаны нийслэл Ташкент гэж сайхан хот бий. Улаанбаатараас ялигүй их буюу хоёр сая гаруй хүн амтай. Элсэн цөл дээр шахам оршдог, айхтар халуун хот. Манайх шиг тоос шороо босвол босохоор. Гэхдээ тохижилтын ажилчдаас гадна байгууллага, иргэд нь үүрийн дөрөв, таван цагаас эхлээд л хотоо тэр чигт нь усална.



Б.Ганбаяр / ЗГМ

Ангасан хотын зовлон

Ингээд иргэд ажилдаа явахад чийг үнэртсэн сайхан агаар утгана. Энэ нь их халууныг бууруулах өөр нэг давуу талтай. Усжуулалтын системээ цогцоор нь шийдсэн болохоор тийм ч их явдал чирэгдэл болдоггүй аж.

Манай нийслэлийн удирдлагууд маань зүлэг ногоогоо услаад л байна. Угаасаа өдийд энэ ажил эхэлдэг. Гэхдээ машинаар усаа зөөж, хотын төв хэсгийн зам дагуух багахан газрыг л шүршдэг. Шатахуун түлшнээс авахуулаад зардал их гардаг болохоор бүх хэсэгт хүрч чаддаггүй бололтой. Тиймээс хотын төвөөс алрах тусам ус чийгний үнэр огт байхгүй болно. Ингээд л иргэд хаврын хавсарга, улаанаараа эргэлдсэн шороотой нүүр тулахаас аргагүй болно доо. Ангасан хотын иргэдийн хувьд хур бороо л сүүлийн найдвар болох шинжтэй. Харин тэр бороо нь хэзээ орохыг бүү мэд. Орсон ч тоос шороог хэсэгхэн зуур л намдаана.

“Азийн саарал дагина” болсон хотын зовлонг захын хорооллын иргэд хамгийн ихээр мэдэрч байгаа. Тоостой замаар хатируулсаар автобусны буудал дээр ирэхэд хэдэн цэвэрлэгч том дэрсэн шүүрээр шороо шүүрдээд угтах вий. Эргэн

тойронд нь битүү тоос. Уг нь хогоо шүүрдэхээс өмнө ус цацаж зөөлрүүлдэг бол ингэж их тоос босохгүй шүү дээ.

Сүүлийн үед тоос тоосонцор жилийн дөрвөн улирлын турш стандартаас давах болсон

Ер нь зүлэг ургаж, хот ноогоорохоос нааш шороо тоосны зовлонгоос сална гэж горьдолтгүй. Хатаж ангасан хөрс багахан салхи дэгдэх төдийд л шороогоор туршиж, “уураа гаргана”. Тэднийг услах ёстой атал хатааж тарчлаасан болохоор уурлахаас ч яахав.

MCS компани хэрэглэсэн усаа цэвэршүүлж, дахин хэрэглэж болох технологи нэвтрүүлсэн. Гэвч дахин боловсруулсан саарал усныхаа тавхан хувийг ашиглаж, үлдсэнийг нь бохирын хоолойгоор урсгахаас өөр аргагүйд хүрдгээ учирлаж байв. Төв цэвэрлэх байгууламж руу зүгээр урсаж буй энэ их усыг ундандаа хэрэглэдэггүй юм аа

гэхэд ядаж гудамж талбайгаа усалж болмоор. Гэвч үнэгүй өгье гээд байхад нь авах газар олддоггүй хорвоод ховорхон тогтолцоо зөвхөн манайд л байна.

Хэдэн жилийн өмнө Дэлхийн банкнаас санхүүжүүлсэн “Цэвэр агаар” төслийн хүрээнд Улаанбаатар хотын агаарын бохирдлын судалгаа хийсэн. Судалгаанаас харвал Улаанбаатар хотын тоос тоосонцорын хэмжээ АНУ-ын цөлийн бүс дэх хотоос ч их байжээ. Бид цөл дунд орших хотоос ч дор агаараар амьсгалж буй нь эмгэнэлтэй биш гэж үү.

“Өвөл ихэнх бодис стандартаас дандаа давдаг. Харин зун хэвийн хэмжээнд байдаг юм. Гэхдээ сүүлийн үед тоос тоосонцор жилийн дөрвөн улирлын турш стандартаас үлэмж их хэмжээгээр давах гээд байдаг болчихлоо. Энэ нь автомашины хөдөлгөөн, шороон шуурга гээд хэд хэдэн шалтгаантай. Ер нь манайд агаарын бохирдлын судалгаа орхигдоод байдаг. Уг нь ихэнх оронд үүнийг шинжилж, судлах бие даасан хүрээлэн бий. Харин манайд хүрээлэнгийн хэмжээнд биш, ганц нэг жижиг лаборатори л байна” хэмээн Байгаль орчин, хэмжилзүйн төв лабораторийн агаарын хэсгийн инженер Б.Бархасрагчаа ярьсан.

Бидний багад хотын хаа сайгүй усалгааны систем суурилуулсан байсныг санаж байна. Хэдэн тийшээ ус цацраад, нэг л таатай. Зуны их халууныг дарах, тоос шороог багасгах хамгийн үр дүнтэй арга байв. Харин одоо энэ бүгд түүх болон устжээ.

Нийслэлийн өмнөх удирдлагын мөрийн хөтөлбөрт ногоон байгууламж, нуур цөөрөм, усан оргилуур байгуулах замаар агаарын чийгшлийг нэмэгдүүлэх асуудал багтсан. Мөн Э.Баг-Үүл дарга нэгэнтээ “Нийслэлийн бүх газрыг нэг бол ногоон зүлэг, эсвэл асфальт болгоно” хэмээн ярьж байв. Гэвч дарга тэсгээдэггүй Монголын өмнөх удирдлагуудын нэгэн адил санаснаа гүйцэлдүүлж чадаагүй. Улмаар улсын маань нийслэл тоос шороондоо дарагдсан, хатаж ангасан хэвээр царай алдан үлдсэн юм.

Уг нь усан оргилуур олноор байгуулна гэдэг тун зөв санаа. Хотын төрхөнд өнгө нэмэхээс гадна их халууныг бууруулж, ойр хавийнхаа тоос шороог ч дарна. Дэлхийн том хотууд үүнийг аль эрт мэдэрч, гоёмсог усан оргилуураар хоорондоо өрсөлдөх болсон. Зарим хотод шинээр барилга барьж буй бол эргэн тойронд нь заавал усан

оргилуур хийх ёстой гэсэн журам хүртэл үйлчилдэг.

Манайхан нэг үеэ бодвол усан оргилуурын ач холбогдлыг ойлгож, дэмжиж байгаа. Шинээр баригдах хотхон, орон сууцанд усан оргилуур байгуулах шаардлагыг хотын зүгээс тавьдаг. Үр дүнд нь хэдхэн жилийн дотор усан оргилуурын тоо 139 болж нэмэгджээ. Гэвч ихэнх нь нүд хуурсан төдий хэврэг юм хийгээд дараа нь мартаж орхидог. Тиймээс байнга ажиллаж байгааг нь тоолбол гарын 10 хуруунд багтааар цөөн гэхэд хилсдэхгүй. Central Tower болон Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн оргилуур л тогтмол ажилладаг байх. Харин бусад нь алдаг оног, дийлэнх нь огт ажиллахаа больсон. Хөрөнгө зарж усан оргилуур босгодог хэрнээ дараа нь түүнийгээ арчилж тордохгүй болохоор яаж ч ажиллах билээ.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хотуудын агаарын бохирдлыг судалж, аюултай хотуудыг зарладаг. Хамгийн сүүлд энэхүү жагсаалтад 1215 хот багтжээ. Энэтхэг, Пакистаны хотууд эхний 10 байрыг хуваан эзэлсэн байна. Манайхан яаж дутахав, найман хот энэ жагсаалтад нэрээ бичүүлэв. Нэг нь мэдэгж Улаанбаатар. Нийслэл маань 44-т оржээ. Үүнээс гадна Дархан, Эрдэнэт, Мөрөн, Ховд, Цэцэрлэг, Баянхонгор, Сүхбаатар хот бохир хотуудын дансанд нэрээ хараар тэмдэглүүлсэн юм. Агаар, хөрсний бохирдол нийслэлийн хэмжээнээс хальж, аймгийн төвүүдэд аюулын харанга дэлдэх хэмжээнд хүрснийг эндээс харж болно.

Монгол хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэж бид Үндсэн хуульдаа заасан. Ийм орчныг бүрдүүлэх нь засаг төрийн үүрэг. Харин бидний сонгосон удирдлагууд үүргээ тун хангалтгүй биелүүлсээр ирснийг гандуу хотын бүүдгэр төрх сануулсаар.

Хотын одоогийн удирдлага ажлаа аваад нэг жил ч болоогүй учраас элдвээр шүүмжилж дайрах нь зүйд нийцэхгүй байх. Хэрэв С.Батболдын баг хаврын хавсарганаар дэгдэн босдог шорооны зовлонг шийдэж, ангаж хатсан хотыг усалж чадвал олон хүн талархах нь лавтай. Магадгүй энэ нь дараагийн сонгуульд ялах нэг том хөзөр ч байх юм бил үү. [ЗГМ]

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



Экологи

ЗГМ: ТОДРУУЛГА



Б.Ганбаяр / ЗГМ©

САНСАР Агаар мандалтай шинэ гараг олдов



Эх дэлхийтэй төстэй, амьдрал үүсэх боломжтой гараг олох хүсэлдээ эрдэмтэд нэг алхам ойртлоо. АНУ-ын одон орны нийгэмлэгээс гаргадаг “Одон орны сэтгүүл”-д дэлхийтэй төстэй агаар мандал бүхий “Gliese 1132 b” гарагийн тухай нийтэлжээ. Тус гараг нь дэлхийгээс 39 гэрлийн жилийн зайд, галактикийн зүүн хэсэгт Вела одны ордод байрладаг. Диаметр нь дэлхийнхээс 20 хувиар урт бөгөөд 1.6 дахин хүнд жинтэй.

“Gliese 1132 b” гарагийн агаар мандал нь ус эсвэл метанаар баялаг гэж эрдэмтэд үзжээ. Тус гарагийн гадаргуу нь цельсийн 260 хэм халуун учраас гаднаасаа час улаан, ууршсан байдалтай харагддаг аж. Гэхдээ судлаачид тус гараг гадна талдаа хэт халуун ч дотроо үүнээс сэрүүн байх боломжтой хэмээн таамаглаж байна. Учир нь өтгөн агаар мандал нь гадаргууны халууныг сааруулдаг байх магадлалтай аж. Мөн тус гарагийн тойрог замын төв буюу “нар” нь манай галактикийн нарнаас илүү сэрүүн, бүүдгэр юм байна.

Кийлийн их сургуулийн судлаач Жон Соуворт “260 градусын халуунд амьдрал үүсэх боломжгүй. Гэхдээ ийм жижиг гарагт агаар мандал байгаа нь бидэнд итгэл, найдвар төрүүлж байна. Ертөнц дээр үүн шиг хэмжээтэй асар олон гараг бий” гэжээ.

“Gliese 1132 b”-г анх 2015 онд Чилид байрладаг Европын одон орон судлалын төвийнхөн нээсэн юм байна. [ЗГМ]

Монгол орны цаг агаар 1940 оноос хойш буюу 70 гаруй жилийн хугацаанд дунджаар 2.1 градусар дулаарч, хур тунадас 10 орчим хувиар буурчээ.

Өнгөрсөн жилийнхээс бага зэрэг сэрүүн зун болно

Олон жилийн дунджаас 0.5-1 хэм дулаан байх төлөвтэй

Б.Баярмаа @bayarmaaZGM

Дэлхийн агаарын дундаж хэм зогсолтгүй нэмэгдэж, өнгөрсөн жил түүхэнд байгаагүй халуун

зун болсон. Европт 40, Ойрхи Дорнодод 50 хэм хүртэл халж, олон жилийн дунджаас 0.94 хэмээр илүү халсан билээ. Харин Монгол орны цаг агаар 1940 оноос хойш буюу 70 гаруй жилийн хугацаанд дунджаар 2.1 хэмээр дулаарч, хур тунадас 10 орчим хувиар буурсан байна.

Ирэх сард болон энэ зуны турш цаг агаарын төлөв ямар байх талаар Цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгийн Урьдчилан мэдээлэх хэлтсийн технологийн Ч.Сарантуяагаас тодрууллаа.



лов ямар байх вэ?

-Тавдугаар сард ихэнх нутгаар сэрүүвтэр байна. Хур тунадас нутгийн хойд хэсэг болон зүүн өмнөд хэсгээр дунджаас ахиу орох төлөвтэй. Харин баруун

өмнөд хэсгээр дунджаас бага орно. Ер нь тавдугаар сард уулархаг нутгаар дунджаар 5-9, говийн нутгаар 15-19, бусад нутгаар 14-19 хэм дулаан байдаг. Хур тунадас говийн нутгаар дунджаар 3-11, бусад нутгаар 12-20 мм унадаг.

-Зуны эхээр хур тунадас хэр орох вэ?

-Нутгийн өмнөд хэсгээр олон жилийн дунджаас ахиувар хур тунадастай. Нутгийн хойд хэсгээр илүү дулаан байна.

-Долдугаар сард өмнөх жилүүдтэй харьцуулахад хэр дулаан байх бол?

-Зуны дунд сард нутгийн

хойд хэсэгт дунджаар 12-17, говьд 22-27, бусад нутгаар 17-21 хэм дулаан байдаг. Энэ зун олон жилийн дунджаас 0.5-1 хэмээр дулаан байх төлөвтэй. Өөрөөр хэлбэл, цаг агаар өнгөрсөн зуныхаас бага зэрэг сэрүүн байна. Үүнээс илүү нарийвчилсан төлөв байдлын мэдээлэл одоогоор гараагүй байна.

-Өнгөрсөн зун олон жилийн дунджаас хэр дулаан байсан бэ?

-Баруун, төв, зүүн аймгуудын нутгаар олон жилийн дунджаас 2-4 градус дулаан байсан. [ЗГМ]

-Ирэх сард цаг агаарын тө-

АМЬД ЕРТӨНЦ

Хавдрыг ялж буй “чөтгөрүүд”

Дэлхийн хамгийн догшин зантай, зэвүүцэм төрхтэй амьтдын тоонд тасманийн чөтгөрүүд ордог. Австралийн Тасманийн арал дээр амьдардаг энэ уутат амьтны тоо 1990-ээд онд 130-150 мянга байсан бол өдгөө ердөө 10-15 мянга болжээ. Ийнхүү цөөрсөн гол шалтгаан нь DFTD буюу нүүрний хорт хавдар аж. Энэ төрлийн хавдар анх 1996 онд бүртгэгдэж, түүнээс хойш тасманийн чөтгөрүүдийн 80 хувь нь үүгээр өвчилжээ. Тэд нэгнийхээ нүүр, хүзүүний хэсэгт хазахад шүлсээр нь дамжин халдварлаж, цаашид

биеийн бусад хэсэгт тархдаг байна. Халдварласан бол 2-3 сарын дотор үхэлд хүргэдэг аж. Хэрэв нүүрний хавдрын эсрэг вакцин олохгүй бол 2035 он гэхэд дэлхийн хамгийн том уутат махчин энэ амьтан бүр мөсөн мөхнө гэж таамаглажээ. Эрдэмтэд вакцин гаргаж авах олон туршилт хийсэн ч амжилтад хүрээгүй.

Гэтэл сүүлийн жилүүдэд халдвар авсан тасманийн чөтгөрүүдийн амьдрах хугацаа уртасч, 1-3 жил болжээ. Өнгөрсөн сард энэ амьтад 20 жил нүүрлэсэн хорт хавдрыг анх удаа

ялж чаджээ. Тэдний дархлааны систем 1990 оноос хойш хорт хавдартай тэмцсээр, богино хугацаанд өөрчлөгдсөн байна. Эм тасманийн чөтгөрийн сүүнд кателицидин гэдэг нянгийн эсрэг бодис нэмэгджээ.

Уутат амьтдын анх төрөхөд дархлааны систем нь бүрдээгүй байдаг аж. Харин эхийнхээ уутанд байж, сүүгээ хөхөх хугацаанд бүрэлдэн тогтдог юм байна. Тиймээс залуу тасманийн чөтгөрүүд кателицидины найрлагатай сүү ууснаар нүүрний хорт хавдрын эсрэг дархлаатай болж чаджээ. Сүүний



найрлага нь олон төрлийн эмэнд тэсвэртэй бактерийг устгах боломжтой антибиотик бүтээх

эх сурвалж болох магадлалтай гэж судлаачид үзэж байна. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ
СОНИН ХМХ

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шуударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас: 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532

Гадаад контент, соёл-энтэртайментын алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Г.Лхагвасүрэн
Утас: 99903581

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

Zasag.Co
“Чөлөөт хэвлэл”
сангийн хэвлэх үйлдвэрт хэвлэв
Дугаарын удирдагч
Л.Сугармаа



8658000429112 00613

Шилдэг САНАА

Bloomberg TV Mongolia

Урлагийн ертөнцийн гоц авьяастнуудтай уулзуулдаг “Шилдэг санаа” нэвтрүүлгийн энэ удаагийн дугаарт Жауме Пленза оролцож байна. Тэрбээр олон нийтийн газруудад зориулсан хөшөө дурсгал бүтээдэг дэлхийн хамгийн алдартай уран барималчдын нэг юм. Түүний бүтээлүүд Риогоос Калгари, Нью-Йоркоос Токио хүртэл дэлхийн том хотуудын гудамж талбайг чимж байдаг. Тэрээр ган төмөр, шил, хүрэл, гэрэл, ус, бүр дуу-авиан бүтээлүүдээрээ дамжуулан оршин буй орон зай, амьдарч буй газар нутгийнх нь талаарх хүмүүсийн ойлголтыг өөрчлөхийг зорьдог.

Баасан гараг /2017.04.14/

11:30

20:30 Бямба гараг

16:00 Ням гараг

ЗГМ: Сэдэв

Ядарсан улсын арчаагүй цамаархал

Шил авдаг хүмүүс хуванцар цуглуулдаг болсон

“Монгол Улсын хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүний сав суулга болон барилгын шил, шилэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зах зээл гадаадаас 100 хувь хамааралтай. Үүнд манайхаас жилд ойролцоогоор 130 тэрбум төгрөг буюу 87 сая ам.доллар зарцуулдаг” гэсэн байна.

Хоёрдугаарт, шилэн савны хаягдал байгальд шингэх гэж 4000 жил болдог аж. Монголчуудын дундаж насалтыг 65 гэж үзвэл, биднээс хойш 61 шахам үе бидний хаясан нэг шилний хор уршгийг амсах нь. Үүнээс харахад л шилэн савыг хаях нь бидэнд ерөөсөө тохирохгүй гэдэг нь тодорхой байна. Байдал энэ мэтээр үргэлжилбэл өндөр үнээр импортлодог шилэн савнуудаа Монгол Улс хэдхэн жилийн дараа дарагдах нь.

Нэрээ нууцлахыг хүссэн нэгэн эх сурвалж “Монголын зах зээлд жилд 10 сая шилтэй өргөст хэмжээгээр зарагддаг гэж бодоход манайх нэг саяыг л нийлүүлнэ. Гэтэл манайд эргээд ирдэг шил нь 50-60 мянга л байна. Тэгэхээр ийм цөөхөн шилний төлөө угааж, цэвэрлэх тоног төхөөрөмж авчирна гэдэг шинэ шил авахаас нэг дахин өндөр зардалтай байдаг. Монголд шилний үйлдвэр байхгүй болохоор Хятадаас л авдаг. Дундаж хэмжээтэй шил 400-500 төгрөгний үнэтэй” гэлээ.

Бид өрхийн шилэн савтай хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ, хаягдлыг тодорхойлохоор 140 гаруй өрхөөс судалгаа авсан юм. Судалгаанд оролцогчдын 76 хувь нь шилэн савлагаатай даршилсан бүтээгдэхүүн, жимсний чанамал түлхүү хэрэглэдэг гэж хариулжээ. Харин 16 хувь нь архи, ундаа, найман хувь нь бусад шилэн савлагаатай бүтээгдэхүүн хэрэглэдэг аж. Шилэн саваа яадаг вэ гэсэн асуултад 34 хувь нь шууд хаядаг, мөн хувь нь цуглуулж



Б.Ганбаяр / ЗГМ

байгаад дахин ашигладаг гэв. 17 хувь нь цуглуулж байгаад хүнд өгдөг бол 14 хувь нь яахаа мэдэхгүй цуглуулдаг байна. Энэ бол зөвхөн айл өрхийн сарын хэрэглээг хамарсан судалгаа. Үүнээс гадна зоогийн газар, үйлчилгээний байгууллага, баяр ёслолын үеэрх хэрэглээ гээд асар өргөн хүрээг хамруулах боломжтой.

Нэг шилний импортын үнэ 400-500 төгрөг

Монгол Улс шилний түүхий эд болох элсийг их хэмжээгээр экспортолж, эргээд боловсруулсан бүтээгдэхүүнийг өндөр үнээр авч байна. Бид нэг шилэн сав 400-500 төгрөг байдгийг олж мэдсэн. Тэгвэл, нэг шилийг буцааж тушаагаад, дараагийн авах бүтээгдэхүүнээс мөн хэмжээний, боломжгүй бол угаах зардлыг хассан тодорхой хувиар хөнгөлж авдаг бол шилээ

хаяж цамаархах хүн олдохгүй биз. Өнөө маргаашгүй шилний үйлдвэр байгуулах төсөв, санхүүжилт бидэнд байхгүй. Тиймээс хэрэгжүүлж болохуйц арга хэмжээг авах нь зүйтэй.

Иргэдийн зүгээс шил авах цэгүүд ойролцоо байвал, шилээ тушаахад асуудалгүй гэж үзэж байна. Магадгүй ойролцоох дэлгүүрт тодорхой үнээр тушаадаг эсвэл сардаа нэг удаа хаягдал шилнүүдийг цуглуулдаг ч байж болох. Ойр орчмын дэлгүүрүүдэд яагаад шил тушааж болохгүй гэж. Хөл залгах унаатай нь унаандаа, унаагүй нь хөрсдөө дайгаад ч гэсэн шилэн савнуудаа өгөөд явуулж болно шүү дээ.

ОХУ-ын “Махеев” брэндийн жимсний чанамалын шилэн сав аяга шиг хэлбэртэй. Мөн зузаан учир дараа нь байнга ашиглах боломжтой. Эзэгтэй нар “Уг нь “Махеев”-ийн чанамал шиг савлагаатай бол байнга хэрэглэдэг байж болно” гэсэн юм. Харин зарим нь “Гэртээ ногоо дардаггүй болохоор хадгалаад ч нэмэргүй байдаг. Хүмүүс гэртээ ногоо дарах нь багассан байна

лээ. 2000 оноос өмнө гэртээ дарсан ногоо л иддэг байлаа шүү дээ” хэмээсэн юм.

Монголд ганц шилний үйлдвэр байсан нь Налайхынх. “Элстийн гол”-ын элсний ордыг түшиглэн 1958 онд Налайхын шилний үйлдвэрийг байгуулсан түүхтэй. Налайхын шилний үйлдвэрийн жилийн тооцоолсон хэрэгцээ 4900 тонн бөгөөд лонхонд ашигладаг ногоон, хөх өнгийн чанар муутай шил үйлдвэрлэдэг байв. 1981-1982 оны байдлаар Налайхын шилний үйлдвэр жилд 1500 тонн элс ашиглан 1.4 сая гаруй ширхэг пиво, ундааны шил үйлдвэрлэж байлаа. Монголд сайн чанарын шил хийх элс байхгүй, хоёр хэсэг газарт л

найрлагадаа металлын холцгуй шилний түүхий эд болох элс бий. Энэ нь Буйр нуурын орчим, мөн Молдог элс. Молдог элсийг 1981 оноос эхлэн ашиглаж жилд 2000 тонн элсээр бараан өнгийн лонх хийдэг болсон. Харамсалтай нь, зах зээлийн нийгэмд шилжиж, өмч хувьчлалаар замхарсан билээ.

Одоо манайд цэвэр шилээр дагнасан ганц үйлдвэр байгаа нь Макс шил, цонхны үйлдвэр юм. “Макс шил” компани 2013 онд дотоодын хөрөнгө оруулалттайгаар байгуулагдсан. Тус үйлдвэр Итали, Солонгос, Хятад улсын өндөр хүчин чадалтай орчин үеийн шилдэг тоног төхөөрөмжөөр мод, шил, хуванцар үйлдвэрлэж байна.

ЗГМ:ТОДРУУЛГА

“Хэрэглэгчид шилээ цэвэрлээд өгвөл болохгүй гэх газаргүй”

Хүнсний бүтээгдэхүүний шилэн савыг дахин ашиглах, дотооддоо үйлдвэрлэх талаар “Газар шим” компанийн захирал Ц.Ганбатаас зарим зүйлийг тодрууллаа.

-Монголд шилний үйлдвэр байхгүй болохоор байнга импортлож байгаа юу?

-Манай компани шилнүүдээ Хятадаас авдаг. Оросоос сайн шил олдохгүй, бас хол болохоор үнэтэй тусдаг. Хятадаас 550 миллиграммын нэг шил авахад л 300 төгрөг давна шүү. Тэвээр нь ч их үнэтэй. Хоосон шил л онгоцоор зөөж байгаа хэрэг шүү дээ.

-Танд дотооддоо шил үйлдвэрлэх талаар бодсон, судалсан зүйл бий юу?

-Би өөрөө шилний үйлдвэр сонирхоогүй, харин үйлдвэрлэх хүсэлтэй, энэ талаар судалж байгаа хүмүүстэй уулзсан. Манайд хамгийн өргөн хэрэглэгддэг шил бол шар айрагны лонх. Том үйлдвэрүүдэд нэг хэвийнхийг 10, 20 саяар нь үйлдвэрлэх хэрэгцээ бий. Жилийн хэрэглээ нь 40, 50 сая литр юм чинь. Дотооддоо шил үйлдвэрлэвэл их хэмжээгээр нийлүүлж болох хоёр дахь хэрэглэгч нь архины үйлдвэр. Дараа нь консервны үйлдвэрүүд орох байх. Монголд бол зах зээл байгаа.

-Газар шим үйлдвэр шилнийхээ хэдэн хувийг угааж хэрэглэдэг вэ?

-Үйлдвэр байгуулагдаад удаагүй, улирлын чанартай ажиллаж байхад улирлын бус үед нь шил өөрсдөө угааж үзсэн. Гэхдээ жимсний чанамалын шил л гэхэд бохирдол ихтэй учир хүнсний үйлдвэрдээ нэг

газарт угаахад тохиромжгүйг ойлгосон. Тиймээс одоо хоёрдогч шилийг угааж нийлүүлдэг ганц, хоёр газар бий. Тэд тодорхой цэгүүдээс шил авч, бидний тавьсан шаардлагын дагуу угааж нийлүүлснийг нь шалгаж аваад 140 хэмд уураар цэвэрлэдэг. Угаасан шил нийт савны таван хувийг л эзэлж байна даа.

-Угаасан шил хэрэглэх хүндрэлтэй байдаг уу. Яагаад нийм бага хувь эзэлж байна вэ?

-Хоёрдогч шилнүүд жигд биш, Герман, Польш, Вьетнам гэх мэт олон орны өөр өөр хэлбэр хэмжээтэй байх нь бий. Тиймээс үйлдвэрийн тоног төхөөрөмжид таарахгүй байх талтай. Тэр болгоныг шалгаж авна гэдэг ажиллагаа ихтэй, хүндрэлтэй л дээ. Импортын шилийг бол хайрцаг савнаас нь суллаад, механик ажиллагаагаар ариутгаад л хэрэглэхэд болдог.

Монгол Улс шилний түүхий эд болох элсийг их хэмжээгээр экспортолж, эргээд боловсруулсан бүтээгдэхүүнийг өндөр үнээр худалдан авч байна.

Хоосон шил л онгоцоор авчраад байгаа шүү дээ

-Хэрэглэгчид шилнүүдээ буцааж өгөх хүсэлт тавилаа гэж бодоход консервны үйлдвэрүүдэд ашиггүй юм байна, тийм үү?

-Бид өөрсдөө бол шил авахгүй. Хэрэв хүмүүс шил өгье гэвэл угааж өгдөг тусгай газруудтай холбож өгч болно. Тэр газрууд

голдуу хоёрдогч түүхий эд нийлүүлдэг газруудаас л шилээ авна.

-Хэрэв хэмжээ нь таарсан шил өгвөл консервны үйлдвэрүүд угааж хэрэглэдэг шилэн савныхаа тоог нэмэгдүүлэхэд нээлттэй гэж ойлгож болох уу?

-Манай үйлдвэрт угааж нийлүүлдэг хүмүүс бидний тавьсан шаардлагыг хангадаг. Хоёрдогч шилийг угааж хэрэглэхэд ямар ч нөхцөлд шинийг авснаас илүү хямд унаас. Бага зэрэг ажиллагаатай ч гэсэн шил цуглуулдаг, угаадаг хүмүүст, цаашлаад байгаль орчинд ч ээлтэй.

-Хэрэглэгчид “Газар шим”-ээс авсан бүтээгдэхүүнийхээ шилэн савыг эргүүлж өгөөд дараагийн бүтээгдэхүүнээ тодорхой хэмжээгээр хямдруулж авч болох уу?

-Бид нэг хэсэг үүнийг туршиж үзсэн л дээ. Гэвч хүмүүс дотроо үлдэгдэлтэй, хоолтой, өмхийрсөн, хөгцөрсөн шил авчирч өгдөг. Түүнийг угаахад маш их бохирдол гарна. Хэрэв анхан шатны угаалгыг хийж ирдэг болчихвол болохгүй гэх газаргүй.

-Нэгдсэн зохион байгуулалт л хэрэгтэй байна гэж ойлголоо. Хэрэглэгчид шилээ угаадаг, үйлдвэрүүд тушаах цэгийг нь ойртуулаад хялбарчлаад өгдөг ч юм уу?

-Тийм ээ. Одоо үед шил, хоёрдогч түүхий эд тушаах цэгүүдийг хотын төвөөс холдуулчихсан. Хүн сардаа 10, 20 шил цуглуулаад хотын зах руу очиж тушаана гэхээр дүндээ дүн болж, цаг заваа алдах учир цааргалдаг байх. Хялбарчлаад, зохион байгуулчихвал олон талын ашигтай. [ЗГМ]



СЭЗИС-ИЙН НЭРЭМЖИТ АНГЛИ ХЭЛ, МАТЕМАТИКИЙН VII, НИЙГМИЙН ТУХАЙ МЭДЛЭГИЙН АНХДУГААР ОЛИМПИАД

СЭЗИС-ийн нэрэмжит англи хэл, математикийн VII, нийгмийн тухай мэдлэгийн анхдугаар олимпиадыг Ерөнхий боловсролын сургуулийн 12-р ангийн сурагчдын дунд 2017 оны 5-р сарын 13-наас 23-ны өдрүүдэд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод зохион байгуулна.

БҮРТГЭЛ:

- Улаанбаатар хотод 2017 оны 4-р сарын 17-ноос 5-р сарын 19-ний өдрүүдийн 13.00-17.00 цагт СЭЗИС-ийн В байрны 801 тоотод;
- Дархан хотод 4-р сарын 17-ноос 5-р сарын 12-ны өдрүүдэд “Монгол Оюу” сургуулийн 210 тоотод;
- Эрдэнэт хотод 4-р сарын 17-ноос 5-р сарын 12-ны өдрүүдэд 1-р сургуулийн 37 тоотод тус тус бүртгэнэ.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

1. 3x4 хэмжээтэй цээж зураг 2%
2. Иргэний үнэмлэх /Төрсний гэрчилгээ/
3. Сурагчийн үнэмлэх /Хувийн хэрэг/
4. Бүртгэлийн хураамж:
 - Улаанбаатар хотод 10.000 ₮ /олимпиад тус бүрт/
 - Орон нутагт 5.000 ₮ /олимпиад тус бүрт/

ОЛИМПИАДЫН ТӨРӨЛ: Математик, англи хэл, нийгмийн тухай мэдлэгийн олимпиадад зэрэг болон, эсвэл сонирхсон төрөлдөө оролцох боломжтой.

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ: Олимпиадын төрөл тус бүрээр байр эзлүүлэн медаль, өргөмжлөөр шагнаж урамшуулна. Математик, англи хэлний болон математик, нийгмийн тухай мэдлэгийн нийлбэр дүнгээр Улаанбаатар хотод эхний 10 хүртэл, Дархан, Эрдэнэт хотод эхний 5 хүртэл байранд орсон сурагчдад СЭЗИС-д 2017-2018 оны хичээлийн жилд элсэн суралцах “ЭРХИЙН БИЧИГ” олгоно.

ЭРХИЙН БИЧИГ: Математик, англи хэлний нийлбэр дүн (бүлэг II, III) болон Математик, нийгмийн тухай мэдлэгийн нийлбэр дүн (бүлэг IV)-ээр Улаанбаатар хотод эхний 10 хүртэл, Дархан, Эрдэнэт хотод эхний 5 хүртэл байранд орсон сурагчдад тус тус СЭЗИС-д 2017-2018 оны хичээлийн жилд элсэн суралцах “ЭРХИЙН БИЧИГ” олгоно.

ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУГАЦАА

Улаанбаатар хотод 2017 оны 5-р сарын 21-ний өдөр
Математикийн олимпиад **10.00** цагаас;
Англи хэлний олимпиад **14.00** цагаас;
Нийгмийн тухай мэдлэгийн олимпиад **17.30** цагаас тус тус СЭЗИС дээр зохион байгуулагдана.
Дархан, Эрдэнэт хотуудад 2016 оны 5-р сарын 13-ны өдөр
Математикийн олимпиад **10.00** цагаас;
Англи хэлний олимпиад **14.00** цагаас;
Нийгмийн тухай мэдлэгийн олимпиад **17.30** цагаас тус тус хуваарьт сургууль дээр зохион байгуулагдана.

ЖИЧ: Дархан, Эрдэнэт хотод зохион байгуулсан олимпиадын эрхийн бичгийг Улаанбаатар хотоос бусад газраас оролцсон сурагчдад олгоно.
Эрхийн бичиг авсан сурагчид тухайн хичээлээр ЭЕШ заавал өгсөн байна.

СЭЗИС, Олимпиад зохион байгуулах комисс

Ивээн тэтгэгч: Voice of America FM106.6
Холбоо барих утас: 88022666 /математик/, 99289990 /англи хэл/, 99990956 /нийгмийн тухай мэдлэг/


Технологи

ЗАГВАР


Пүүзний
намрын өнгө
"Futurecraft
4D"

"Adidas" компанийн 3D хэвлэмэл пүүзний 5000 ширхэг "Futurecraft 4D" загвар энэ намар, өвлөөс жижиг дэлгүүрүүдээр дамжин энгийн хэрэглэгчдэд хүрч эхлэх нь. Харин ирэх оноос үүнээс олон тоогоор үйлдвэрлэж эхлэх бөгөөд 2018 оны эцэс гэхэд 100 мянган ширхгийг борлуулах төлөвлөгөөтэй байна. Гэхдээ "Futurecraft 4D" загварыг яг хаана үйлдвэрлэж байгаа талаарх мэдээллийг нууцалж байна.

"Adidas" корпораци Цахиурын хөндийн старт-ап болох "Carbon"-той хамтран "Futurecraft 4D" пүүзийг бүтээж эхэлсэн. Пүүзний дунд давхаргыг гэрэлд улам бат бэх болдог будаг бүхий принтерээр хэвлэсэн юм. Пүүзний түүхийг эд нь будгийн тогтоц сайтай нэгэн төрлийн резин материал бөгөөд энгийн гуталд төдий л тохиромжгүй эд аж. Уг материал нэгэн бүхэл бөгөөд ийн хэвлэсний дараа хэт ягаан туяагаар хээг нь бат бэх болтол нь шардаг. Ингэснээр 3D принтерээр гарсан бусад бүтээгдэхүүнээс 100 дахин бага хугацаа зарцуулдаг талаар компанийн төлөөлөгч ярьсан байна.



Түүнчлэн "Futurecraft 4D" пүүзийг хэрэглэгчийн захиалгаар үйлдвэрлэхээр бэлтгэж буй аж. [31W]

Бүсгүйчүүдийг
онилсон аппликейшнФимтекийн
хөрөнгө оруулалтын
хэлэлцээрийн
тоо 2.5 дахин
нэмэгджээ

З.Гэрэл
ЗГМ

Кэти Бьюмонт хэмээх бүсгүйн хүүхэдтэй болох гэсэн оролдлого хоёр жилийн өмнөөс эхэлжээ. Тэрбээр хэддүгээр сард жирэмсэлбэл хамгийн сайн болохыг олж мэдэхээр эмэгтэйчүүдэд зориулсан сарын мөчлөг болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд тогтмол хянах маш олон аппликейшнийг хэрэглэсэн байна.

Өдөр бүр температураа үзэж, мэдээллийг нь "Fertility Friend" хэмээх аппликейшнд оруулж, уйгагүй чармайж байсан ч эцэстээ өөрийгөө төрөхийн шаналалд орж, галзуурахаас наахна болсноо олж мэджээ.

Хэдийгээр өдөр бүр оруулж буй мэдээлэлд нь үндэслэн аппликейшн үр тогтсон гэдгийг хэлж байсан ч зургаан сарын дараа ч жирэмсэн болж чадаагүй байснаа хуваалцсан байна. Тэрбээр "Боломжтой үеэ алдсан байж магадгүй гэж бодох үе байсан. Гэвч хичээх тусам шаналал нэмэгдэж байсан" гэж ярьсан байна.

Гэхдээ эмэгтэйчүүдэд зориулсан аппликейшн бүр алдаатай байдаг гэвэл үгүй. 35 настай Сара Фликт дөрвөн жилийн өмнөөс "Natural Cycles" хэмээх аппликейшн хэрэглэж эхэлжээ. "Natural Cycles" мөн л тухайн хэрэглэгчийн температурын мэдээлэлд тулгуурлан хэзээ жирэмсэлж, бас жирэмсэлтээс хамгаалахыг хэлж өгдөг. Сара аппликейшнийг гурван жил ашиглаад, өнгөрсөн жил жирэмсэлсэн байна.

Кэти, сара нар эмэгтэйчүүдэд зориулсан аппликейшнийг жирэмсэн болох, сарын мөчлөгийн талаарх ойлголтоо зузаатгах зорилгоор хэрэглэдэг сая сая эмэгтэйн төлөөлөл.

Эмэгтэйчүүдийг онилсон


фимтек (femtech)-ийн зах зээл сүүлийн жилүүдэд огцом тэлж байна. Энэ төрлийн старт-апын санхүүжилт ч нэмэгдэж буйг олон улсын "CB Insights" группийн технологийн шинжээч Зой Ливитт хэлэв. Зөвхөн Британид л гэхэд сүүлийн гурван жилийн хугацаанд фимтекийн хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн тоо 2.5 дахин нэмэгдэж, 540.5 сая ам.долларт хүрсэн байна. Тус компанийн бүртгэлээр 2009 оноос хойш эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндэд зориулсан аппликейшний хөрөнгө оруулалт 1.26 тэрбум ам.доллараар хэмжигдэж буй аж. Фимтекийн зүүсгэл технологи ч гараад иржээ.

Харамсалтай нь эмэгтэйчүүдийн зарим хэсэг энэ аппликейшнийг боол болж буйг нийтлэлийн эхний жишээ нэвт тодорхой ойлгож болно. Гэхдээ энэ орон зайд байгаа бүтээгдэхүүний хэрэглээ зөвхөн жирэмсэн болох хүсэлтэй, эсвэл сэргийлэхийг хүссэн эмэгтэйчүүдээр хязгаарлагдаагүй. Германы старт-ап, таван сая хэрэглэгчтэй "Clue"-г

үүсгэн байгуулагч Ида Тин "Аппликейшнийг тусламжтай магадгүй ихэнх хүн анх удаа өөрийнхөө биед орж, юу болж буйг бодитоор нь харж байгаа биз. Бие болоод эрүүл мэнд нь сайн, хэвийн байгааг мэдэх гэсэн хүслээр фимтекийг хэрэглэдэг хэрэглэгч олон" гэв.

Харин Их Британийн Эрүүл мэнд, сувилахуйн үндэсний хүрээлэнгээс хэрэглэгчдэд аппликейшнийг хязгаартай хэрэглэх заавар өгсөн байна. Өөрөөр хэлбэл, аппликейшн хөгжүүлэгчдийн амалж байгаа шиг үр дүнг хүлээх хэрэггүй гэдгийг сэрэмжлүүлдэг аж.

Гэвч фимтекийг жирэмсэн болох, сарын мөчлөгийн талаарх ойлголтоо зузаатгах зорилгоор хэрэглэдэг сая сая эмэгтэй дэлхий дахинд бий. Фимтекийн зах зээл гэрэлтэй байна. Ирээдүйд улам тэлэх нь гарцаагүй. Эмэгтэйчүүдийн эрүүл мэндээ гадна хувь хүний эрүүл ахуй, нярайн асаргаа, хөхний саалтуурын талаар ч боловсронгуй, хэрэглэхэд дөхөмтэй фимтек хэрэгцээтэй байгаа аж. [31W]

СТАРТ-АП БИЗНЕС
Халуун, шинэ
пицца

Роботууд хэрэглэгчдийн гар дээр халуун, шинэхэн пицца хүрэх боломжийг бүрдүүлж эхэллээ. АНУ-ын Калифорни муж улсад "Zume pizza" пиццаны газар үйл ажиллагаандаа хүнс хийгээд технологийг гайхалтай хослуулж байна. Бруно нэртэй робот хольцуудыг пиццаны гурил дээр нарийн тогтоосон хэмжээ, дарааллын дагуу байрлуулдаг аж.

Мөн дотроо 56 шарах шүүгээтэй том оврын машиныг түгээлтэндээ ашигладаг. Нэг пиццаг болгоход ойролцоогоор 3.30 минут зарцуулдаг байна. Автомашинд ч гэсэн Валенсио хэмээх нэртэй робот пиццануудыг шарах шүүгээнд хийх ажлыг гүйцэтгэдэг аж.

"Zume pizza"-г үүсгэн байгуулагчийн ярьж буйгаар цалингийн зардлыг хэмнэснээр хэрэглэгчдэд хүрэх пиццаг илүү чанартай, эрүүл хүнсээр хийх боломжтой болж буйг онцолжээ. [31W]

САНСАР

Хятад сарны
гадарга дээр

Өмнөд хөршийн Сарны судалгааны хөтөлбөрийн багийнхан сар руу олон удаагийн нислэг үйлдэх боломжтой сансрын хөлөг бүтээхээр ажиллаж байна. Уг хөтөлбөрийн эхний үе шатанд дэлхийн дагуулыг тойрон нисэх, сарны гадарга дээр газардах зориулалт бүхий сансрын хөлөг бүтээхээр ажиллаж байна.

Мөн уг хөлгийнхөө багтаамжинд ч анхаарч буй бөгөөд дөрвөн хүний багтаамжтай хөлөг бүтээж буйгаа Хятадын сансрын хөлгийн жолоодлогын товчооны ахлах инженер Жан Байнан тодотгосон аж. Гэхдээ 2036 оноос нааш олон удаагийн нислэг үйлдэх боломжтой сансрын хөлгөөр хүн тээвэрлэхгүй гэдгээ сарны судалгааны удирдлагууд мэдэгджээ. [31W]



UBshop.mn

ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ПЛАТФОРМ

Юу авмаар байна? Юу зармаар байна?

АВТОМАШИН

- 1 SONATA-6 маш хямд зарна 2-3 хоногийн өмнө орж ирсэн. Утас: 96481125
- 2 Ачааны зориулалттай автомашин маш хямд зарна. Утас: 96481125, 99087992
- 3 Mercedes Benz E-200 дизель авто машин зарна. 2004 оны 2011 онд орж ирсэн дизель 2000cc автомат. Хот дотор 10 иднэ. Германаас орж ирсэн. Тогтмол дулаан гражид байдаг. Хар өнгөтэй E 200. Утас: 99289768
- 4 225/60/R16 Kumho Solus дугуй зарна. Утас: 99135791
- 5 Nissan Teana зарна. Утас: 99796159
- 6 2001 оны 2012 орж ирсэн. ямар ч асуудалгүй Prius 11 зарна. Утас: 99892976
- 7 Ачааны зориулалттай автомашин маш хямд зарна Утас: 96481125, 99087992
- 8 Автомашин хагарч цуурсан шил наагч зарна. Утас: 99679962

КОМПЬЮТЕР БА
ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ

- 1 Skynet-ийн modem зарна. Утас: 80286525, 86203222
- 2 3 дугаар үеийн i5 процессор, 2 GB ram, 583 GB хард диск, 15.6" дэлгэц бүхий Toshiba Satellite C850 модель нөүтбүүкийг утасгүй маус, цүнхний хамт зарна. Утас: 95530099
- 3 Оригинал Wifi хүлээн авагч хямд зарна. 150 метр хүлээн авна. Утас: 91228822, 95228822
- 4 Notebook үнэ тохирч худалдаж авна. Ломбарднаас чөлөөлж авна. Утас: 91228822 95228822
- 5 900x400x2mm pad хямд зарна. Утас: 91228822, 95228822
- 6 Пронон хамгаалалттай, 5.5 см диаметртай. Хүмүүсийн сонирхлыг татахуйц дизайнтай, гар утас, компьютер, нөүтбүүк, бусад төхөөрөмжинд залгаж болно. LED гэрэлтэй, дотроо батарейтай. 3.5mm аудио, USB цэнэглэгч кабель дагалдана. Өнгөний сонголттой. Утас: 96012938, 88512938

ҮЛ ХӨДЛӨХ

- 1 40 тонн контейнер маш хямд зарна. Утас: 90666913 96481125
- 2 Ар хустайн зусланд цэвэр агаарт хаус зарна. Утас: 99289768
- 3 Ар хустайн зусланд цэвэр агаарт хаус зарна. Утас: 99289768
- 4 2 өрөө үйлчилгээ явуулах боломжтой байр зарна БЗД 8-р хороо Баянзүрх хотхон 108-р байрны 1-р давхарт дэлгүүр, сургалт, цэцэрлэг, үйлчилгээ явуулах боломжтой 43 мкв 2 өрөө байр хямд зарна. Хаяг: Офицерийн тойргоос уруудаад Баянзүрх хотхон 108-р байр Утас: 80612065
- 5 Апартамент-88 орон сууц ХЯМД зарна УТАС: 99289768 Сансарын тунелд 1 давхарын 3 өрөө байр зарна. Утас: 99760217, 99101271
- 6 Хотын төвд бүрэн тавилгатай пентхаус гал тогоо тусдаа 5 өрөө байр хөлслүүднэ. Утас: 99760217, 99101271
- 7 Сансар Цагдаа хотхоны зүүн талд 2016он ашиглалтанд орсон 2 өрөө 41,1 мк2 байр хямд зарна. Утас: 91228822, 95228822
- 8 Засвар хийсэн 1 өрөө байр түрээслүүнэ.наран талдаа цонхтой. Утас: 99188626, 86269918
- 9 Төв аймагт 6 айлын зуслангийн газар зарна. Утас: 95347403

НОМ, ХЭВЛЭЛ

- 1 "МАНАН БУДАН" Цоо шинэ зарна. Утас: 85828384
- 2 Бүх төрлийн ном хэвлэл худалдаалж байна. Утас: 99144154
- 3 Хуучин номнууд зарна. Утас: 94640105
- 4 Бизнес удирдлагын магистерийн ангид хэрэглэгдэх 2003-2008 оны Pearsons international edition номнуудыг тус бүр тойргоос уруудаад Баянзүрх хотхон зарна. Утас: 99153637
- 5 Ээж ба хүүхэд ном зарна. Утас: 99089401
- 6 Сэргэн мандалтын үеийн нэрт зураачдын бүтээлийг өнгөтөөр хэвлэж, орос хэлээр нийтэлсэн Монголд цөөн байдаг уран зургийн ном зарна. Утас: 99625921
- 7 Official guide of TOEFL TEST 4th edition. Хэрэглэж байсан мөн дисктэйгээ. Утас: 99674312
- 8 Түүхийн хэдэн зуун үйл явдлыг Чингисийн үеийн их бага тулалдаанаас авахуулаад Хадгаламж зээлийн хоршооны хэрэг хүртэл бүртгэн багтаасан. Чингисийн үеийн хэдэн алдартныг эс тооцвол То ван, Мянгат гэсэн хоёрхон монгол хүн багтсан байдаг бол энэхүү Britannica 8 боть ширээний нэвтэрхий толь зарна. Утас: 88170048

ЦАХИЛГААН БАРАА

- 1 Электрон жин худалдана. Алт, мөнгөн эдлэл болон эмийн тунг жигнэх зориулалтай. Авсаархан хөнгөхөн. LCD дэлгэцтэй. 200 гр хүртэл Хэмжээ: 115X65X15 мм, Жин: 95 гр 1 минутанд автоматаар утарна. Тэжээл: 2 AAA батарей (дагалдахгүй) Ажиллах температур: 10-30 хэм (C) Утас: 88512938, 96012938
- 2 USB гагнуурын алх. Агшин зуур хална, хөрнө. 480 C градус хүртэл хална.



Утас: 96012938

ГАР УТАС

- 1 Америкийн BLU брэндийн STUDIO X8 HD гар утас -2 СИМ-тэй. Утас: 96012938, 8851293
- 2 50-60 мянгад Android утас худалдаж авна. Note1 f100 f200 гэх мэт. Утас: 91228822 95228822
- 3 iPhone 7 plus black 128GB цоо шинэ хайрцагнаас нь задлаагүй. 128GB. 2 сая 400-аас яриад өгнө. Утас: 93117711, 89808313
- 4 Хар багта арилгагч гурвалсан үйлчилгээтэй маск зарна. Утас: 88857871
- 5 Samsung.Note.3 32gb 4.4.4.version Korea хамгийн өндөр үзүүлэлттэй цэмбэгэр утас хямд зарна. Чихэвч дагалдана. Утас: 91228822, 95228822

UBSHOP.MN

ubshop.mn сайтад та зараа байрлуулбал манай сонинны зарын энэ хэсэгт шууд орох юм. Зөвхөн кирил үсгээр бичсэн, холбоо барих утас, зарах үнэ нь тодорхой зарууд энэ хэсэгт орохыг анхаарна уу.



Залуус

Э.Оюунбилэг: Гэр бүлээ ирээдүйд гэр хороололд амьдруулахгүй

«Дунд болон их, дээд сургуулиа хаана, ямар мэргэжлээр төгссөн бэ. Багадаа ер нь ямар хүүхэд байсан бол гэдэг сонирхол татаад байна?»

-51 дүгээр дунд сургуулийг төгсөж, “Сити” дээд сургуулийг зочид буудал, зоогийн газрын менежмент мэргэжлээр дүүргэсэн. Одоохондоо загвар өмсөгчөөр ажиллаж байгаа. Аав, ээж болон дүүтэйгээ дөрвүүлээ амьдардаг. Бүх хүний мэдсэнчлэн гэр хороололд. Манай эгч тусдаа гарсан. Эхээс гурвуулаа. 17 жилийн дараа дүүтэй болсон. Уг нь айлын бага, аавын эрх охин байсан юм. Тэгсэн дүү маань төрөөд жийгдсэн дээ (инээмсэглэв). Арван жилдээ хүний нүдэнд өртөхөөргүй жижиг, намхан, туранхай, доожоо муутай хүүхэд байсан. Биеийн тамирын хичээл ороход сүүлээсээ тав, зургаад л зогсдог байлаа. Харин сурлагын хувьд гайгүй шүү. Хэл уран зохиол талдаа илүү сонирхолтой. Мөн хөдөлмөр, зургийн хичээл зэрэг бүтээлч зүйлд дуртай. Ерөнхий боловсролын сургуулиа төгсөөд аав, ээжийнхээ ятгалгаар ХААИС-д бараа, түүхий эдийн технологичоор суралцсан. Манай гэрийнхний хувьд нэлээд хуучинсаг үзэлтэй. Заавал улсын сургууль төгсөх ёстой гэсэн зарчимтай. Гэхдээ хоёр жил л тэнд сурсан. Учир нь төгсөөд энэ мэргэжлээр ажиллахгүй гэдгээ мэдсэн болохоор сургуулиа солихоор шийдсэн юм. Би өөрөө зочид буудал, зоогийн газрын менежментийг их сонирхдог байсан. Явцын дунд ч бүтэхгүй гэдгийг маань гэрийнхэн мэдэж, “Сити” дээд сургуульд гуравдугаар дамжаанаас шилжүүлэн сургуулиа дүүргэсэн дээ.

“Багадаа нэлээд намхан байсан гэлээ. Хэзээнээс яагаад гэнэт өсчхөв. Танай гэрийнхэн өндөр хүмүүс үү?”

-Есдүгээр ангидаа баруун хөлөө хугалаад хоёр орчим сар ямар ч хөдөлгөөнгүй хэвтсэн. Шаганаас гуя хүртлээ битүү гипстэй. Хөл эдгэрч, хичээлдээ эргээд ортол бага зэрэг өссөн байсан. Тэрнээс хойш маш эрчимтэй өссөн. Зуны амралт дуусаж, эргээд хичээлдээ орох бүрт өсөөд л. Сүүлдээ ангийнхаасаа хамгийн өндөр нь болчихсон. Хамгийн анх агентлагт ороход миний өндөр 1.76 метр байсан бол одоо 1.82 болсон. Юунаас болж, яагаад өссөнөө ойлгоогүй. Гэхдээ манай аав ээжийн талынхан мөч урттай, өндөр хүмүүс байдаг.

“Загварын ертөнцөд анх хэрхэн хол тавьсан бэ. Яагаад энэ мэргэжлийг сонгох болов. Эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах боломж бий юү?”

-Наймдугаар ангидаа хэтэрхий туранхайгаасаа ичиж, биеэ нуун нэлэмгэр өмд, цамц өмсөж, эрэгтэйлэг алхдаг, үсээ дагзан дээрээ боодог хүүхэд байсан. Ээж маань намайг эмэгтэйлэг болгохгүй бол болохгүй нь гээд зуны амралтаар “Лэди” төвд явуулсан. Тэгсэн “Лэди” төвд загварын алхаа заасан. Өсгийтэй гутал өмсөөд алхтал манай багш модель болж болох юм гэсэн. Сургуульд загварын тэмцээний удирдамж ирээд, загвар өмсдөг хоёр эгч намайг ороод үз гэсэн санал тавьсан. Тэмцээнд шилдэг 30-д үлдээд хасагдсан. Тэр үед ер нь бүтэхгүй юм байна гэж бодож байлаа. Удалгүй Азийн модель агентлагаас над руу залгаад, “А” зэрэгцээний загвар өмсөгчөөр ажиллах санал тавьсан. Арван жилийн хүүхэд байсан болохоор тухайн үед жижиг сажиж зураг авалтад ороод 20-30 мянган төгрөг олчихдог. Сургуулийнхаа хоолны газарт бараг л ганцаараа хоол идээд сууж байдаг баян сурагч байсан. Дараа нь “Андра” агентлагт орж, тэндээ л загвар өмсөгчөөр ажиллах гараа маань эхэлсэн. Дараа нь топ модел Т.Болормаа багштайгаа танилцаж, “Монгол модель”-д



Хувийн архиваас

орсон. Үүнээс хойш байнгын шоу, зураг авалтад оролцож, жилийн дараа Сингапурын “New model agency”-тэй гурван сарын гэрээ хийж, гадаадад олон зүйл сурч мэдсэн.

“Модель гэж яг ямар хүнийг хэлдэг вэ. “Mongolia’s next top model” тэмцээний үеэр мисс, модель хоёрыг ялгаж салгах хэрэгтэй гэсэн яриа гарсан шүү дээ?”

-Модель хүн байнга сайхан харагдаж, өсгийтэй гутал, даашир өмсөх албагүй. Дэлхийн стандартад моделиуд хамгийн энгийн хэрнээ өөрсдийн гэсэн тодоод ертөнц, үзэл бодолтой хүмүүс байдаг. Модель хүн тухайн дизайнерын хувцасыг тайзан дээр болон зураг авалтын үеэр амилуулах үүрэгтэй. Түүнээс биш энгийн амьдрал дээр өөрийнхөөрөө л байх хэрэгтэй. Гэтэл Монголд олон нийтийн газраар нүүрээ будаагүй явах төдийд хүмүүс үүнийг шүүмжилдэг. Миссүүдийн тухайд бүх хүнд гоо сайхан харагдах ёстой шүү дээ. Манайхан одоохондоо энэ хоёрыг ялгаж салгах болоогүй байх шиг.

Тэмцээний дараа аягүй мундаг ахаас зүй бус санал ирсэн

“Тэмцээний дараа ажлын санал олон ирсэн үү?”

-Тэмцээн дууссанаас хойш бараг өдөр бүр завгүй, олон загварын шоу, зураг авалтад орсоор байна. Томоохон ажлын тухайд “Дархан минж” компанитай хамтран шинэ каталогийн зураг авалтад орсон. Мөн “Говь” компанид орсон.

“Тэмцээний үеэр олон удаа хасагдах дөхсөн. Тэр болгонд Оргил шүүгч чамайг дараад байх шиг санагдсан. Чамд тийм хандлага мэдрэгдсэн үү?”

-Эхэндээ Оргил шүүгчийг намайг хурцалж, илүү цааш яваасай гэж бодсондоо шүүмжилж байна гэж бодсон. Тэгээд өдөр бүр маш их хичээж, хамаг чадлаа шавхсан. Тиймдээ ч шилдэг гуравт үлдсэн байх. Гэтэл сайжраад байхад Оргил шүүгчийн хандлага огтхон ч

өөрчлөгдөөгүй. Яагаад тэгснийг нь одоо болтол ойлгоогүй, өөрөөс нь ч асуугаагүй. Нэг үе үнэхээр шантарч, зохион байгуулагчдад тэмцээнээс гарах хүсэлт тавьсан. Яаж ч хичээсэн хандлага нь өөрчлөгдөхгүй учир цаашид хичээх шаардлагагүй гэж бодсон. Гэтэл манай охид болон нэвтрүүлгийн багийнхан яагаад ганцхан хүний үнэмлэмжээр өөрийн хүсэл мөрөөдлөө орхих гэж, дэмжиж байгаа олон хүний итгэлийг бодох хэрэгтэй гэсэн. Үүнээс хойш нэлээд хурцлагдаж, өөртөө итгэлтэй болж, олон зүйлийг сурсан шүү.

“Олны танил болсны дараа мөнгөтэй, эрх мэдэлтэй хүмүүсээс янз бүрийн санал ирдэг гэж сонссон. Чамд ийм санал ирж байв уу?”

-Загвар өмсөгчдөд тиймэрхүү санал байнга л ирдэг. Чи ингэж амьдрах ёсгүй, сайхан амьдруулах өгье, хаус, машин авч өгье гэх мэт. Гоё, үнэхээр гоё сонсогддог. Хялбар аргаар олсон мөнгө хүнд юм болдог гэж сонсож байгаагүй. Хүний эрхэнд байснаас өөрийн зовж олсон мөнгөө хэрэгтэй зүйлд зарцуулсан нь дээр гэж боддог.

“Гэр чинь хаана байдаг билээ?”

-Манайх дэнжийн 1000-д байдаг. Эндээс маш ойрхон. (V дугаар сургууль)

“Гэр хороололд амьдардаг гэхэд чинь олон нийт итгээгүй. Хасагдсаны дараа танайд үнэхдээ л хүмүүст итгэл очиншил төрсөн шүү дээ?”

-Би агентлагт ороод тав орчим жил болж байна. Энэ хугацаанд манай найз нөхдийн хүрээлэлд намайг хаана амьдардаггүй хэн ч мэддэггүй байсан. Гэхдээ энэ бол ичээд, нуугаад байхаар асуудал биш. Тухайн хүний хаана амьдардаг нь тийм ч чухал биш болов уу. Хүмүүсийн сэтгэгдлийг харахад дийлэнх нь “Гэр хорооллын халтар охин. Энэ өрөвдүүлэх гэсэн тэмцээн биш” гэж байлаа. Миний хувьд энэ тухай гаргахыг хүсээгүй. Нэвтрүүлгийн зүгээс хүмүүсийн буруу хандлага бүхий яриаг засахын тулд гэрт чинь гэрэгж

өгье гэсэн санал тавьсан. Хэн л өөрийнхөө амьдралыг хүн бүрт дэлгэхийг хүсэх вэ дээ. Энэ мэтчилэн саар яриаг гаргасан хүмүүст хандаж хэлэхэд хүн хаана, яаж амьдрах нь хэнд ч хамаагүй. Хамгийн гол нь биеэ зөв авч явж, зөв хүмүүжилтэй, зөв амьдарч байвал бүх зүйл болно. Гэр хороололд амьдардаг гээд хэн нэгнээр өрөвдүүлэхийг хүсээгүй. Бас нэг яриа гарсан байна лээ. Гэр хороололд амьдрал гэрээс нь худлаа. Өөрөө гэртээ байдаггүй. Фэйсбүүк, инстаграмм хуудсанд даанда тансаг байшинд авахуулсан зураг тавьсан гэх мэтчилэн. Ямар муухай хүмүүс вэ. Манай эмээ, эгчийнх байранд байдаг. Би тэр хүмүүсийнд байхпаа зургаа авахуулсан шүү дээ. Би гэрт амьдардаг гээд зургаа оруулах албагүй. Гэртээ аав, ээж, дүүтэйгээ галаа түлээд, хоолоо хийгээд, усандаа яваад, дүүгээ цэцэрлэгээс нь аваад амьдарч л явна.

“Гэр чинь хаана байдаг билээ?”

-Манайх дэнжийн 1000-д байдаг. Эндээс маш ойрхон. (V дугаар сургууль)

“Танайх угаасаа тэндхийн айл уу?”

-Манайх 2000 онд Дорнод аймгаас гэр бүлээрээ хотод шилжин суурьшсан. Дөнгөж ирсэнийхээ дараа 25 дугаар эмийн сан хавьцаа эмээгийн дээ амьдардаг байлаа. Монгол айлуудын адил гурван өрөө байранд маш олон гэр бүлийн хамт байдаг байв. Оройн хоол болохоор бүгдэд нь нэг аяга хоол ногдохоос илүү гарахгүй. Илүү идэх, эсвэл хоосон хонохгүй тийм л амьдралтай. Хотод дөнгөж орж ирсэн үе манай гэр бүлийн маань хувьд хүнд цаг үе байсан. Аав маань Дорнодоос хот руу явах замдаа авто осолд орж, хүзүүнээс бусад бүх мөчөө хугалж, хагас жил орчим сэхээнд, гурван жил хэвтэрт байсан. Аав байнгын асаргаанд байсан учир ээж ажил хийж чадахгүй, эгч бид хоёр цэцэрлэгтээ өөрсдөө явж, ирдэг байлаа. Үүнээс болж манай аав, ээж ажиллах насан дээрээ бусад шиг мөнгө төгрөг хурааж амьдрал ахуйгаа дээшлүүлж чадаагүй юм. Аав ээж маань ажил хөдөлмөр эрхэлсэн бол одоогийнх шиг байхгүй л байсан байх. Гэхдээ би ингэж амьдарсандаа огтхон ч харамсдаггүй. Хамгийн гол нь элэг бүтэн, өвчин зовлонгүй байх нь хамгийн том аз жаргал. Мөнгө төгрөгөөр илүү гараагүй ч гэсэн хайран дунд өссөндөө хамгийн ихээр баярладаг.

“Аав нь гэхдээ хөл дээрээ боссон биз дээ?”

-Аав одоо “Шинэ дэлхий” телевизэд харуул хийдэг. Ээж дүүг хараад гэртээ байгаа. Манайх 2005 онд Дэнжийн 1000 руу нүүсэн. Аав гурван жилийн дараа хөл дээрээ босож, нэгэн байгууллагад харуул хийж эхэлсэн. Цалин бага учраас аав, ээж хоёр БНСУ руу ажил явахгаар бүртгүүлсэн. Гэтэл ээж тэнцээгүй. Харин аав тэнцээд, намайг зургадугаар ангид байхад гэрээгээр БНСУ руу цалин авлаа гэхэд 200-г нь гэр рүүгээ явуулаад үлдсэнийг нь хадгаламжиндаа хадгалдаг байсан. Гурван жилийн дараа гэрээ нь дуусаад хоёр жил хараар ажиллаж байгаад гэнэт баригдаж, Монголд ирсэн. Хадгаламжин дахь мөнгөө очиж авч чадахгүй байсаар байгаад өнгөрсөн. Дараа нь би БНСУ-д очоод шалгаад үзтэл данс нь хаагдчихсан байсан.

“Үнэхээр харамсалтай зүйл болсон байна?”

-Би есдүгээр ангиасаа хойш гэрийнхнээсээ мөнгө аваагүй. Ажил хийгээд өөрийгөө болгочихдог байсан. Миний их сургуулийн төлбөрийг АНУ-д амьдардаг аавын маань төрсөн

эгч төлсөн. Хичээлийнхээ хажуугаар зөвөгч хийж авсан цалингаараа гэрийнхэндээ гоё юм авч өгөх нь надад ямар их сэтгэл ханамж өгдөг гээч. Магадгүй ингэж амьдарсан амьдрал илүү амттай, намайг хэрсүү, ухаалаг болгосон байх гэж боддог. Тиймээс л энэ амьдралдаа огтхон ч харамсдаггүй.

“Гэр бүл төлөвлөлтийн талаар ямар бодолтой явдаг вэ. Найз залуутай юу?”

-Би одоо 22 настай. Өөрийгөө авч явах хэмжээний чадалтай болтлоо хүнтэй суух бодолгүй байна. Нөхөр болох хүнийхээ хамт хүссэн амжилтандаа хүрээд, хүүхэдтэй болж, унах унаатай, дулаан орон сууцтай, нэг өдөр хоолгүй хонохгүй байх амьдралын баталгаатай гэр бүл болохыг боддог. Найз залуутайгаа үерхээд дөрвөн сар болж байна.

Модель хүн байнга сайхан харагдах албагүй

“Цаашдын төлөвлөгөө юу байна. Мэдээж хэрэг орон сууцтай болох талаар бодож байгаа байх?”

-Одоохондоо миний олж байгаа орлого идэж уух, өмсөж зүүхээс хэтрэхгүй байна. Ер нь гадагшаа явахгаар төлөвлөсөн. Европ, ялангуяа Герман руу гарах сонирхолтой байгаа. Зорилгодоо алхам алхамаар ойртохын тулд хичээсээр явна. Таван жилийн дараа ийм байшинтай болсон гээд фэйсбүүкт зураг тавих байх. Гэр бүлээ ирээдүйд гэр хороололд амьдруулахгүй ээ.

“Хоол хийхээс өөр ямар хообийтой вэ?”

-Миний хувьд хүнтэй юм яриад байх тийм ч дуртай биш. Ганцаараа байх илүү сонирхолтой. Стрессээ янз бүрийн хоол хийж тайлдаг. Ааваараа хоол хийлгэхийг багаасаа заалгасан. Эгч бид хоёр зураг зурах хообийтой. Эгч интерьер дизайнер, би зураг төслийн хүн болно гэж ярьдаг байв. Тэгсэн аав битгий элдэв янзын юм рүү үсчээд бай гэж болиулсан. Дараа нь хувцас оёж сурсан. Ойр зуурын өөрийнхөө өмсдөг майк, шинэ жилийн даашинз зэргийг оёчихдог. Саяхан ээж бид хоёр оёдлын машин худалдаж авсан. Тэгээд “Монгол модель” агентлагийнхаа эмэгтэй загвар өмсөгчдийн халаадыг оёсон шүү.

“Ярилцсанд баярлалаа. [ЭМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017-04-12

Тендер шалгаруулалтын нэр: Микроавтобус нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: MC-53/2017

“ДЦС-4” ТӨХК эрх бүхий тендер оролцогчдоос Микроавтобус нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50000 төгрөгийг Хаан банк 5038008126 тоот дансанд тушаасан баримт авчран худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2015, 2016 онуудын жил бүрийн борлуулалт нь санал болгосон үнийн дүнгээс багагүй байх**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:**

Тендерийн санал болгосон үнийн дүнгээс багагүй байх

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан: 2015 он, 2016 оныг ирүүлэх**Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл:** 2 жил**Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл:** шаардлагатай

Тендерийн хамт 2%-ийн тендерийн баталгаа ирүүлнэ. Мөн тендерийн баталгааг Засгийн газрын бондоор ирүүлж болно.

Тендерийг 2017 оны 05 дүгээр сарын 12-ны 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 05 дүгээр сарын 12-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг 20 дугаар хороо “ДЦС-4 ТӨХК-ий байр 3 давхар 312, 313 тоот өрөө Утас 7018-1309 7000-1357 7017-1357**Факс 7018-1309 7000-1357**

Лавлах

ХЯНАЛТ ШАЛГАЛТ Хүүхэд харах үйлчилгээг шалгана

Б.Бямба
ЗГМ

Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6540:2015 стандарт зэрэг холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийхээр болжээ. Үнэлгээг ГБХЗХГ-аас улсын хэмжээнд энэ сарын 3-наас ирэх сарын 31 хүртэл хийнэ. Улмаар шаардлага хангахгүй төвүүдэд албан шаардлага өгч, хүүхэд харах үйлчилгээ болон сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн давхардлыг арилгаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах юм байна.

Энэ хууль багтагдсанаар цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байсан 45 мянга гаруй хүүхдийн 25 хувь нь хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж, 1305 иргэн ажлын байртай болжээ. Түүнчлэн ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байсан 6000 гаруй эцэг, эх асран хамгаалагч тодорхой хөдөлмөр эрхэлж, байнгын орлоготой болсон аж. Харин энэ оны нэгдүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 818 төвд 5275 хүүхэд хамрагджээ. [ЗГМ]

АНХААРУУЛГА Хог шатаавал торгоно

Нийслэлд ил задгай хог хаяж, шатаахыг хориглодог. Тэгвэл сүүлийн үед иргэд, албан байгууллага зориулалтын бус бүсэд хог хаяж, шатаах явдал цөөнгүй гарах боллоо. Хог хаягдлын тухай хуулийн 23.1.7-д зааснаар иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөг, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох юм. Өөрөөр хэлбэл, хог шатаасан иргэн 240 мянга, аж ахуйн нэгж, байгууллагад 480 мянган төгрөгийн хариуцлага хүлээлгэнэ. [ЗГМ]

УРАЛДААН Сурагчдын дунд уралдаан зарлав

Татвар төлөгчдийн өдрүүдийг утган орон даяар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион бичлэг, гар зургийн уралдаан зарлалаа. Уралдаан нь ирээдүйн татвар төлөгчдөд татварын мэдлэг олгох, татвар төлөх нийгмийн сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой. Зохион бичлэгийг А4 хэмжээтэй, хоёроос илүүгүй хуудсанд багтааж, монгол хэлний зөв бичгийн дүрмийг баримталж бичих бол гар зургийн бүтээл 40х60 хэмжээтэй ватум цаасан дээр өнгө ялгаж зурсан байна.

Зохион бичлэгийн төрөлд эхний гурван байрт өргөмжлөл болон 100-200 мянган төгрөг, тусгай байрт таван бүтээл шалгаруулан өргөмжлөл, 50 мянган төгрөгөөр шагнана. Уралдаанд оролцох бүтээлийг энэ сарын 22-ныг хүртэл тухайн аймаг, дүүргийн Татварын хэлтэст хүлээн авна. [ЗГМ]

ЗӨВЛӨГӨӨ Давсны зөв хэрэглээ


Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс хүн наснаасаа хамааран хэдий хэмжээний давс хэрэглэж болох талаар зөвлөлөө. Хоногт хэрэглэх давсны зөвшөөрөгдөх дээд хэмжээ;

- 6-12 сартай-1 гр
- 1-3 настай-2 гр
- 4-6 настай-3 гр
- 7-10 настай-4 гр
- 10 дээш настай-5 гр
- Насанд хүрэгсэд-5 гр юм байна. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	09:45 Соно студи: "Маамуу нааш ир"	07:30 "Сайн уу дэлхий" нэвтрүүлэг	09:00 "Cook Club" хоолны шоу нэвтрүүлэг	10:00 "Дөрвийн эсрэг дөрөв" нэвтрүүлэг
12.00	11:00 "Монголын мэдээ" мэдээллийн хөтөлбөр	11:00 "Made In Mongolia: Трансвест Монголиа ХХК" нэвтрүүлэг	12:10 "Гайхалтай аялал" /Хятад 4 дүгээр цуврал/	12:30 "Сонсье, Сурья, Дагая" /season-2/ 78 дугаар хэсэг
14.00	14:00 "Ирээдүйд илгээх захидал" сурагч солилцоо /Архангай Өмнөговь аймаг/	14:00 "Эзэнт гүрнийг босгосон нь" нэвтрүүлэг	14:10 "Зөв үнийг таа" шоу нэвтрүүлэг	15:30 "Бидний таван хүүхэд" СОАК 21 дүгээр анги
18.00	17:05 Нүүдэлчдийн өв соёл: Монгол хоточ нохойн тухай	17:00 "Bloomberg Surveillance"	17:00 "Үүнийг хэрхэн хийдэг вэ?" нэвтрүүлэг 8 дугаар анги	17:30 Төг тог тог /season-3/ 118 дугаар хэсэг
20.00	19:10 "Урлаг" теле сэтгүүл	20:00 "Студио 1.0" нэвтрүүлэг	20:50 "80 саяын уналт" асуулт, хариултын шоу нэвтрүүлэг	19:45 "Зургаан настнууд бидний ирээдүй" нэвтрүүлэг
22.00	22:10 "Дөлгөөн Дон" Оросын УСК 8 дугаар анги	22:30 "Технологийн шийдэл" нэвтрүүлэг	22:00 "Хайр эргэсэн хавар" ОАК 13 дугаар анги	22:30 "Чадвал намайг хуур" ОАК 15 дугаар анги

ЗГМ. ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР.

2. Аргентины шигшээ багийг дэлхийн аварга болоход гол үүрэг гүйцэтгэсэн домогт хөлбөмбөгчин

3. Зам ангиудын товчилсон нэр
4. Энгийн
7. Жанрайсаг бурхны тарни
8. Японы хэвлэл мэдээллийн томоохон

байгууллага

10. Татах, мэдээгүйжих өвчин
11. Байгалийн гамшиг

ХӨНДЛӨНГӨӨР:

1. Манай орны хамгийн том гүрвэл
5. Барилгын өрлөг хийх

материал

6. Ц.Энхманлайгийн зохиосон "Харанга" хамтлагийн алдартай ???
9. Гагнаж эвлүүлсэн хэсэг
12. Ойн зэрлэг жимс
13. Манай улсаас холгүй орших, ОХУ-ын хот

Өмнөх дугаарын хариу / 04.11



ОНЦЛОХ ҮЗВЭР

"Эртний хот суурины соёл"



Хүннүгээс Хятаны үед холбогдох археологийн олдворуудаас дээжлэн толилуулах "Эртний хот суурины соёл" тусгай үзэсгэлэнгийн нээлт өнөөдөр Монголын үндэсний музейд болно. Үзэсгэлэнд Монгол орны нутаг дэвсгэрээс олдсон Монгол-Оросын хамтарсан "Төв-Азийн нүүдэлчдийн хот суурин" төслийн хүрээнд хийсэн нийт 200 орчим үзмэрийг толилуулах юм. Сонирхуулбал, нийтийн тооллын 677 оны орчимд холбогдох Пүгү аймгийн язгууртны бунхант оршуулгаас илэрсэн ховор олдворууд, Хятаны үед холбогдох шүдний ясан сойз, шаазан хүний баримал, ваар сав, хоол хүнсэндээ хэрэглэж байсан загасны яс, хясаа, тарималжуулан хэрэглэж байсан үр тариа, Заамарын бунхант булшнаас илэрсэн шавар, модон хүүхэддэй, туг, хятад бичээстэй хөшөө зэргийг дурдаж болно. [ЗГМ]



ЗГМ: СҮДОКУ

		9			1			
2	5	4			1	7	3	
1		6	8		5			
		4					9	2
			5	4				
		3					4	
8	6				3		4	
		7		3				
1		4	5	8				7

2	9	5	7	6	3	8	1	4
4	8	1	9	2	5	3	6	7
7	6	3	4	8	1	2	9	5
1	2	4	8	9	7	6	5	3
3	7	8	5	1	6	4	2	9
9	5	6	3	4	2	7	8	1
6	1	7	2	5	4	9	3	8
8	4	2	1	3	9	5	7	6
5	3	9	6	7	8	1	4	2

(Өмнөх дугаарын хариу)

ЦАГ АГААР



ЗГМ: КОМИКС

Mr. Баагийгийн ПАЯН.....

Yйлчлэгчээ, энэ шөлөнд чинь юм хөвөөд байна.

Шөл юм чинь мах ногоо хөвөлгүй яахав дээ.

Гүй энэ чинь сэлж хөвөөд байна шүү дээ.

ЛЯ ЛЯ

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

NOMADIC COMICS

ҮЗЭВЭР

УДБЭТ

Монголд анх 1977 онд тоглож байсан "Травиата" дуурийг энэ сарын 15-нд дахин тоглох гэж байна. Гурван бүлэг, дөрвөн үзэгдэлтэй уг дуурийг Урлагийн гавьяат зүтгэлтэн Ё.Цэрэндолгор найруулжээ. Дуурийн таслбарын үнэ 10-20 мянган төгрөг. Монголын балет хөгжлийн сангаас энэ сарын 19, 20-нд "Spirit of ballet" тоглолтыг зохион байгуулна. Уг тоглолтод Монгол, Солонгосын залуу бүжигчид оролцоно.

ХҮҮХЭЛДЭЙН ТЕАТР

Багачуудад зориулсан "Алтанхан залаат азарган тахиа" жүжгийг энэ сарын 29, 30-нд толоно. ОХУ-ын зохиолч Алексей Николаевич Толстойн уг зохиолыг орчин үеийн нийгэм, хүүхдийн сэтгэхүйд тохируулан өөрчилснөөрөө онцлог юм. Жүжгийн тасалбар 5000 төгрөгийн үнэтэй.

УЛААНБААТАР ЧУУЛГА

Хөгжим бүжгийн коллежийн цохивор хөгжмийн шилдэг уран бүтээлчид "Найруулга 2007-2017" тоглолт хийж гэж байна. Уг тоглолтод тус коллежийн уран бүтээлчдийн 10 гаруй жил найруулж, тоглож ирсэн 100 гаруй бүтээлээс сорчлон хүргэнэ. Тоглолт энэ сарын 21, 22-нд болно.

УЛСЫН ФИЛАРМОНИ

"Novel Melody" хөгжмийн концерт энэ нам гарагт 19.00 цагаас болно. Тасалбарын үнэ 20 мянган төгрөг.

ЦОГ ХУДАЛДААНЫ АВТОКОЛЛЕКТОР

"VIP drift show" авто наадам энэ сарын 29-нд болно. Уг наадмыг зургаа дахь жилдээ зохион байгуулж байна.

ЗУРХАЙ



Билгийн тооллын 16

Хаврын дунд харагчин туулай сарын найман цагаан мэнгээтэй, шарагчин могой өдөр.

Үс засуулбал. Өвчин ирнэ

Наран ургах, шингэх. 06.11-19.37 Барилдлага. Үл зохилдох Шүтэн барилдлага. Тийн мэдэхүй

Аргын тооллын дөрөвдүгээр сарын 12, Буд гараг. Билгийн тооллын 16, Салхины эх одтой, шарагчин могой өдөр.

Өдрийн наран 06.11 цагт мандаж, 19.37 цагт жаргана. Тухайн өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сан тавиулах, угаал үйлдэх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, сэтгэлд сэвтэй газар очих, байшингийн суурь тавихад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгтмөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргэлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ГАЛТ ТЭЭРЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

Москва-УБ	21:35	07:30
УБ-Эрхүү	21:10	02:40
Эрхүү-УБ	15:35	06:20
УБ-Замын-Үүд	20:00	07:50
Замын-Үүд-УБ	21:35	09:55
УБ-Эрдэнэт	20:30	07:45
Эрдэнэт-УБ	19:10	05:48
УБ-Сүхбаатар	10:55	19:52
Сүхбаатар-УБ	06:30	15:35
Сайншанд-УБ	20:25	07:01
УБ-Сайншанд	09:15	19:15
Зүүнхараа-УБ	04:25	08:40

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Бээжин	08:15	11:50
Бээжин-УБ	11:30	14:00
Сөүл-УБ	13:00	15:50
УБ-Сөүл	17:10	21:15
Москва-УБ	00:00	07:10
УБ-Москва	08:20	10:10
УБ-Хөх хот	08:00	10:20
Хөх хот-УБ	11:20	14:10
Бэрлин-УБ	13:15	06:15
Токио-УБ	15:30	20:25
УБ-Манжуур	16:50	19:25
Манжуур-УБ	16:50	19:25

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Дэлхийн худалдааг протекционизмээс хамгаалах нь

Олон улсын нөлөө бүхий институциуд Трампын протекционист бодлогын эсрэг байр сууриа нэгтгэж эхэлж байна. > 10

Цахим мэдээллийн үерт живээгүй сонин

Daily Telegraph бол ховорхон “амьтан”. Ашигтай ажилласаар байгаа Британийн цаасан сонин. > 10

Японы хүн ам эрс цөөрөх сануулга

Японы хүн ам 2115 онд 51 сая болтлоо цөөрнө гэж судалгаанд дурджээ. > 10

Меркелгийн бодлогыг залгамжлахаа Шульц мэдэгдэж байна

Ги Шазан

Энэ онд канцлераар сонгогдвол Германы эдийн засгийн чанд бодлогыг хэвээр үргэлжлүүлнэ хэмээн Европын парламентын тэргүүн Мартин Шульц мэдэгдлээ. Уг мэдэгдэл нь Социал демократ намын удирдагч Евро бүсийн талаарх Берлиний бодлогыг өөрчилнө хэмээн горьдож байсан Европын холбооны урмыг хугалав. Ангела Меркелгийн оронд канцлераар сонгогдвол өрийг бууруулах, бүтцийн шинэчлэл хийх Германы бодлогыг онц өөрчлөлтгүйгээр үргэлжлүүлэх тухай ноён Шульц эсгүүлдэд тайлбарлав. Тэрбээр Социал демократ намын удирдагчаар сонгогдоноосоо хойш анх удаа гадаадын хэвлэл мэдээллийн төлөөлөгчдөд ярилцлага өгч байгаа юм.

Европын холбооны гишүүн улсууд тогтвортой хөгжих нь Германы амин чухал эрх ашиг мөн ч, үүний тулд эдгээр улс бүгд тодорхой шинэчлэл



өрнүүлэх шаардлагатайг ноён Шульц онцлон анхаарууллаа. Тэрбээр Европын парламентын ерөнхийлөгч байхдаа эсрэг байр суурь баримталж, ХБНГУ өмнөд Европын улсуудынхтай ижил аялуу бодлого хэрэгжүүлэх нь чухал хэмээн өгүүлж байсантай энэ удаагийн тайлбар зөрчилдөө.

Грекийн өрийн хямрал ид гарсан 2012 онд, Европын холбооны гишүүн 27 улсаас 26 нь Афинд ахиу туслах байр суурьтай байсныг “Гажиг нөхцөл” хэмээн

ноён Шульц үзэж байжээ. Тухайн үед Меркелгийн удирдлага дорх ХБНГУ л бусдынхаа байр суурийг эсэргүүцсэн юм.

Одоо Грек улс Евро бүсэд ямар байр суурь эзлэх вэ гэсэн асуултад тэрбээр “Шинэчлэлээ хэр сайн өрнүүлж чадахаас хамаарна” хэмээн хариулсан. Уг хариулт нь хатагтай Меркель, Сангийн сайд Вольфганг Шойбле нарын хахир бодлогын цууриа юм.

Грек болон Евро бүсийн өрөндөө баригдсан бусад улсын

талаар хэт зөөлөн бодлого явуулдаг хэмээн шүүмжлэгч герман сонгогчдын зүгээс учруулж буй дарамтыг ноён Шойбле гэтлэн давахаар оролдож байна. Германчуудын олонх нь хатагтай Меркель, ноён Шойбле нарыг санхүүгийн сахилга батын үлгэр жишээ хэмээн үздэг. Мөн өмнөд Европын орнуудад тулгарсан хямралт байдлыг илүү хатуу чанга улстөрчдөд даатган шийдвэрлэх нь зүйтэй гэсэн бодолтой.

ZDF TV сувгаар баасан

гарагт нэвтрүүлсэн “улс төрийн барометр”-ийн үзүүлэлтээр Германы сонгогчдын 34 хувь нь Социал демократ намаас өрсөлдөгчтэй харьцуулахад, хатагтай Меркель илүү итгэл хүлээх хүн хэмээн хариулжээ. Мөн 31 хувь нь одоогийн канцлерийг илүү сэтгэлд нийцтэй, 46 хувь нь илүү туршлагатай хэмээн үнэлсэн байна. Ноён Шульц Социал демократ намын өнгөрсөн долоо хоногт явуулсан өөр нэг санал асуулга харууллаа. Уг санал асуулгад хатагтай Меркелгийн консерватив эвсэл 33 хувь, Социал демократ нам 31.5 хувийн санал авсан юм.

Цагтаа хатагтай Меркелгийн зүгээс ширүүн шүүмжлэл хүлэсэн, Евро бонд гаргах замаар Евро бүсийн гишүүн улсуудын өрийг солилцох санаагаа Социал демократ намын удирдагч даваа гарагт давтаж зүрхэлсэнгүй. Уг санаа нь евро бүсийн санхүүгийн тусламжийн сан болох Европын

тогтвортой байдлын механизмыг үүсгэн байгуулсантай уялдаатай хэмээн тэрбээр тайлбарлав.

Ноён Шульцийн ганц л байр суурь түүнийг хатагтай Меркель болон Христийн ардчилсан холбооноос зааглаж, АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамптай зөрчилдөхөд хүргэж болзошгүй.

НАТО-д хүлээсэн үүргээ биелүүлж, ХБНГУ-ын цэргийн зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 1.2 хувиас хоёр хувь болгон өсгөхөөр холбооны Засгийн газар амалсан. АНУ-ын Европ дахь түншүүд, ялангуяа ХБНГУ батлан хамгаалах салбарт хэт багыг зарцуулж, Вашингтонд хэт их найдаж байна хэмээн шүүмжлэгч ноён Трамптай саяхан уулзах үеэрээ хатагтай Меркель уг амлалтаа бататган давтсан юм.

“НАТО-той тохиролцсоны дагуу батлан хамгаалах зардлаа ДНБ-ий хоёр хувьд хүргэх бодлогыг дэмжихгүй” гэдгээ ноён Шульц мэдэгдэж байлаа.



Асадыг дэмжигч ОХУ-ын эсрэг хатуу бодлого баримтална

Жэймс Полити

Сирийн Ерөнхийлөгч Башар Асадыг Кремль дэмжихээ болих хүртэл нь ОХУ-д шахалт үзүүлэх нийтлэг стратегийг “Их 7”-гийн Гадаад хэргийн сайд нар эрэлхийлж байна. “Их 7”-гийн гишүүн улсууд Дамасктай хамтран ажиллаж буй Москваг шүүмжлэх нь ихэссэн ч ОХУ-д тавих шинэ хориг арга хэмжээний талаар санал хуваагдмал.

Өнгөрсөн долоо хоногт химийн зэвсгийн дайралт хийсэн Сирийн дэглэм, уг дайралтын хариуд нуужингийн цохилт өгсөн АНУ хоёрын алиныг нь дэмжихээ Москва сонгох цаг ирлээ хэмээн Италийн Лукка хотод чуулсан уулзалтын эхний өдөр Британийн Гадаад хэргийн сайд Борис Жонсон мэдэгдэв. “Ард түмнээ химийн хороор хөнөөж буй Асадын дэглэмд цавуудчихсан аятай наалдаж байгаа нь ОХУ-ын нэр хүндэд эргээд хор болж байна” хэмээн ноён Жонсон тайлбарласан юм.

АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон энэ долоо хоногт ОХУ-д хийхээр төлөвлөсөн айлчлалынхаа өмнө Москваг хурцаар шүүмжилж, Асадын дэглэмийг “алан хядагч” хэмээн шүүмжилсний дараахан ноён Жонсон дээрх тайлбарыг өглөө. АНУ энгийн иргэдийн эсрэг гэмт хэрэг үйлдэж буй ямар ч улсыг сөрөн зогсох талаар даваа гарагт ноён Тиллерсон мэдэгдэв. Энэ нь Дональд Трамп сонгуулийн кампанийнхаа үеэр тайлбарлаж байсан, хөндлөнгөөс үл оролцох бодлого үндсээрээ өөрчлөгдсөний илрэл боллоо.

“Дэлхийн аль ч газарт, энгийн иргэдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч бүхэнтэй бид тэмцээ сэргээлээ” хэмээн ноён Тиллерсон Италийн Сант Анна ди Стаццема тосгонд үг хэлэхдээ мэдэгдэв. Дэлхийн II дайны үед нацистууд гэм зэмгүй 500 гаруй оршин суугчийг нь бөөнөөр хөнөөсөн ди Стаццема тосгон “Бидний тэмцэлд урам оруулж өглөө” хэмээн ноён Тиллерсон тайлбарлаж байлаа.

“Их 7”-гийн улсууд Кремлийн эсрэг байр сууриа чангатгах бодолтой. Гэхдээ Дамаскийн талд зүтгэж буй орос офицеруудтай холбогдуулан ОХУ-д шинэ хориг тавих тухай Их Британийн

санаачилгад дурамжхан ханддаг. “ОХУ-ын эсрэг хориг тавих нь зөв арга хэрэглүүр биш. Тэгээд ч шуурхай хэрэгжүүлэх боломжгүй” хэмээн “Их 7”-гийн нэгэн дипломат үзэв. “Бид үүссэн хүндрэлийг гэтлэхийн тулд ОХУ-тай аль болох яриа хэлэлцээ өрнүүлэх нь зүйтэй. ОХУ-ыг Сирийн дэглэмтэй эвсэхээс өөр сонголтгүй болтол нь буланд шахаад байж болохгүй. Харин ч эсрэгээр ажиллах шаардлагатай” хэмээн дипломат тайлбарласан юм.

Ноён Тиллерсоныг Москвад айлчлахаас нь өмнө “Их 7” хориг тавьчихвал ОХУ-ыг ягтаа ажил үр дүнгүй өнгөрнө хэмээн өөр нэг дипломат сэрэмжлүүлэв. Ром ч нэмж хориг тавих бодолгүй талаар уг уулзалтыг зохион байгуулж буй Италийн албаны хүн мэдэгдсэн.

ОХУ-д хориг тавих асуудлаар Европын холбооны гишүүн улсууд урьд нь санал зөрөлдөж байсан удаатай. Өнгөрсөн аравдугаар сард Алеппог бөмбөгдсөнтэй холбогдуулан шинэ хориг арга хэмжээ авах шахалтыг Их Британи, Франц, ХБНГУ-ын зүгээс Италид үзүүлж байлаа. Европын дипломатуудтай нэгдсэн Ром энэ удаад Женевт болох, НҮБ-ын дэмжлэгтэй энхийн хэлэлцээрийг сэргээж, гал зогсоох тохиролцоог баталгаатай болгох нь зүйтэй гэсэн байр суурь баримталж байна. “Хурцадмал байдлыг сулруулах үүднээс Москваг Асадын дэглэмээс салтал нь хамтран шахах нь чухал” хэмээн Италийн дээд албаны эрхэм тайлбарлав.

Итали нь “Их 7”-гийн уулзалтын хүрээнд Саудын Араб, Арабын нэгдсэн Эмират, Турк, Йордан улсыг хамтын яриа хэлэлцээнд урьсан. Италийн Гадаад хэргийн сайд Анжелино Альфано Сирийн хямралын талаар Ираны Гадаад хэргийн сайд Мохаммад Жавад Зарифтай ярилцжээ. Сирийн асуудалд төвлөрсөн нь Ливийн нөхцөлийг хоёрдугаарт тавих эрсдэлтэй. Итали нь Файез Сарраж тэргүүтэй Триполи дахь Засгийн газрыг “Их 7”-гийн орнуудаар дэмжүүлэхийг хармаа-саар өдий хүрчээ.



Шинэ Дели татвараа хойшлууллаа



BVM©

“Бараа, үйлчилгээний татвар Энэтхэгт хэрэгтэй. Гэхдээ ийм татварын тогтолцоо хэрэгжүүлэх нь хүнд ажил” хэмээн тэрбээр өгүүлэв. Мужийн татварын одоогийн тогтолцоогоор, аливаа бараа бүтээгдэхүүн мужийн хилээр нэвтэрмэгц олон цаг шаардсан бичиг баримтын нүсэр ажил болж, татвар боддог. Баримт бичгийн тогтоогч авч хаяснаар Энэтхэгийн эдийн засгийн гарц яг хоёр хувиар өснө хэмээн шинжээчид тооцжээ.

Олон удаа хойшлуулж, улс төрийн сөрөг хүчин эсэргүүцэж ирснээс шалтгаалан GST-г хэрэгжүүлэх ажил 10 орчим жилээр саатсан юм. Бараа, үйлчилгээний татварын журмыг Энэтхэгийн парламентын дээд танхим өнгөрсөн долоо хоногт баталсан тул энэ зунаас хэрэгжүүлэх шаардлага тавигчид олширлоо. “Хэтийн алсдаа GST нь маш зөв татвар. Одоогийн татвар ихтэй зарим мужаас захиалга авахтай холбоотой

хүндрэл арилна. Гэхдээ ингэглээ яарах хэрэг юун” хэмээн ноён Малик өгүүлэв.

Төсвийн орлогод тавьдаг хяналтаа алдахаас айсан Шинэ Дели болон мужийн засгийн газрууд харилцан буулт хийж байж татварын шинэ журмыг баталсан. Гэхдээ GST нь нийт Энэтхэгийг хамарсан ердийн нэг татвар төдий бус. Энэтхэгийн төвийн засгийн газар GST-ийн дөрвөн төрөл байхаар тооцоолсон ч ямар бараа, үйлчилгээг аль төрөлд хамруулахыг хараахан шийдвэрлэж амжаагүй. Эцсийн шийдвэрийг үндэсний болон мужуудын улстөрчид ирэх сард хамтран хэлэлцэж шийдвэрлэх тул бизнес эрхлэгчдэд ердөө зургаахан долоо хоногийн бэлтгэл хугацаа үлдэж байна.

“Хувь хэмжээг хэдээр тогтоох нь лут маргаан үүсгэнэ” хэмээн аудитын Ernest & Young компанийн Энэтхэгийн салбарын захирал Судир Кападиа өгүүлэв. Үндсэн дөрвөн төрлөө тодорхойлсон хойно

бараа, бүтээгдэхүүний жижиг дэд ангиллыг мөн үүсгэх шаардлагатай.

Австрали 2000 онд GST хэрэгжүүлэхдээ боловсруулсан хүнсэнд татвар оноож, боловсруулаагүй хүнсний бүтээгдэхүүнийг татвараас чөлөөлөхөөр шийдвэрлэсэн. Гэхдээ боловсруулаагүй хүнсэнд чухам ямар бүтээгдэхүүнийг хамруулах талаар ширүүн маргаан өрнөсөн юм.

Тэртээх 1991 онд Их Британид Jaffa Cakes хэмээх шоколадан бүрмэл амттаныг татвараас чөлөөлөгддөг бялууны төрөлд багтаах уу, эсвэл татвар оноодог жигнэмгийн ангилалд оруулах гэсэн асуудлыг шүүхийн оролцоотой шийдвэрлэж байв.

Юугай ч арилжааны банкууд GST тооцож эхлэх аваас зээлийн хүү өсөж таарна. Мөн буцаагдаж буй бараа бүтээгдэхүүнд GST-г дахин оноох эсэхийг ноён Малик мэдэхсэн гэж байлаа. Энэтхэгийн хувьд нийт улсыг хамарсан Бараа, бүтээгдэхүүний

татварыг шуурхай хэрэгжүүлэх гэж байгаа нь амбийц ихтэй төлөвлөгөө. Австрали GST-г парламентгаар баталсны дараа хэрэгжүүлэх ажилд бүтэн жилийн бэлтгэл шаардсан юм.

“Бичиг баримт боловсруулахтай холбоотой асуудлаас ч болсон юм биш. Биднийг хэт яарч, хуумгай шийдвэр гаргасан талаар шүүмжлэгчид одоо ч олон” хэмээн Австралийн өрсөлдөөний комиссын тэргүүн байсан, профессор Алан Фелс дурсаж байлаа. “Бусад улсын шинэ журамд чадах чинээгээр бизнесээ зохицуулахаас өөр арга үлдсэнгүй. “Татварын тооцоо хийсээр өдрийг бардаг боллоо” хэмээн ноён Малик өгүүлсэн юм.





Зүүн гараас ДХБ-ын ерөнхий захирал Роберто Азеведо, ДБ-ны ерөнхийлөгч Жим Жон Ким, ОУВС-гийн гүйцэтгэх захирал Кристин Лагард нар.

Женевт төвтэй ДХБ-д АНУ мөн тэргүүлэх тоглогч бөгөөд энэ оны эцсээр Аргентинд болох хоёр жилийн уулзалт нь Вашингтоны үүрэг хариуцлагад төвлөрөх шинжтэй байна.

Ерөнхийлөгч Трампын нэрийг цохоогүй боловч ОУВС-гийн захирал Кристин Лагард, Дэлхийн банкны ерөнхийлөгч Жим Жон Ким, ДХБ-ын ерөнхий захирал Роберто Азеведо нар худалдааны давуу талыг өмгөөлсөн үг хэлэх нь нэмэгдсэн байгаа. Тухайлбал, хатагтай Лагард “Худалдааны интеграцилал бол өсөлтийг нэмэгдүүлж, амьдралын стандартыг дээшлүүлэх хүчирхэг хэрэглүүр мөн. Энэ нь дэлхийн өсөлт, хөгжин цэцэглэлтийн хөдөлгүүр байсаар ирсэн” гэжээ. Худалдааг хамгаалахын сацуу тус байгууллагууд Засгийн газруудад хандаж, технологийн дэвшил, автоматизаци, даяарчлалын ард хоцорсон улсуудад тусламж үзүүлэхийг уриалж байна.

Ажилчдад үзүүлэх нөлөөний асуудал эдийн засагчдын халуун маргааны сэдэв болдог. Сүүлийн судалгаанаас үзэхэд Хятадаас импорт нэмэгдэж

болон Их Британи Европын холбооноос гарах болсон нь уг шийдвэрийн төлөө саналаа өгсөн бөгөөд эдийн засгийн шинэчлэлийн ард хоцорсон хүмүүст хэрхэн туслах вэ гэдэг асуулт үүсгэв.

ОУВС, ДХБ, Дэлхийн банкнаас Их 20-ийн уулзалтад зориулж гаргасан тайланд эдийн засгийн өөрчлөлтөд хохирсон иргэдэд туслахын тулд боловсрол, орон сууцны хөтөлбөр, ажилгүйдлийн даатгал гэх мэт зүйл бүрийн арга хэмжээ авахыг Засгийн газруудад хандан уриалсан. Энд түүнчлэн 1960 оны санхүүгийн хямралаас хойш худалдаа жилд зургаан хувиар өсөж ирснийг дурдаад ДХБ болон бусад олон талт систем худалдааны дайныг зогсоосныг онцолжээ. Тайланд Трампын засаг захиргаанаас ДХБ, түүний журамд эргэлзэж буйг шүүмжилсний дээр Засгийн газрууд тус байгууллага болон маргаан таслах системийг хамгаалах ёстой гэсэн байна.

Энд бичсэнээр “ДХБ-д төвлөрсөн дэлхийн худалдааны систем амин чухал хэвээр байна. Маргаан таслах системийг хадгалах нь хэзээ хэзээнээс илүү чухал болсон” гэнэ. Гэвч тийм тайлан нийтлэгдсэн нь улс төрийн нөхцөл байдал нэлээд өөрчлөгдсөнийг харууллаа. Хятадын Ханжоуд 2016 оны есдүгээр сард болсон Их 20-ийн уулзалтын дараагаас тайланг бэлтгэж эхэлсэн бөгөөд Трамп сонгогдох боломж, Европт популизм нэмэгдэж буй зэрэг түгшүүр худалдааны давуу талыг сурталчлах, хоцорсон хүмүүст туслах шаардлагаас үүдсэн байна. Гэхдээ ноён Трамп тавдугаар сард Италид Их долоо, долдугаар сард Германд Их 20-ийн уулзалтад биеэр ирэх үед ийм ил тод шүүмжлэл дахин өрнөхгүй бизээ. **FT**

Дэлхийн худалдааг протекционизмээс хамгаалах нь

Шон Доннан

ОУВС, Дэлхийн банк болон Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон улсын нөлөө бүхий институциуд Трампын протекционист бодлогын эсрэг байр суурина нэгтгэж эхэлж байна. Дэлхийн худалдааны давуу талыг хамгаалах, Дональд

Трампын төлөвлөгөөг шүүмжлэх асуудлаар дээрх гурван байгууллага санаа нэгдсэн нь ховор тохиолдол юм. Даваа гарагт Германы канцлер Ангела Меркелийн ивээл дор Берлинд болсон уулзалт протекционизм өсөн нэмэгдэж буйн эсрэг тэмцэх оролдлого боллоо.

Берлин ийнхүү чөлөөт зах зээл, либерализмын нийслэл болох суурь тавигдаж байгаа бололтой. Вашингтонд болох ОУВС, Дэлхийн банкны бодлогын хүрээнд төв банкны захирлууд, Сангийн сайд нарын уулзалтын өмнө олон талт худалдааг хамгаалах хүчин чармайлт

нэмэгдлээ. Хоёр жилд нэг удаа хийдэг уг уулзалт Трамп сонгогдсоноос хойш анх удаа болох гэж байгаагаар онцлогтой. Энэ хоёр байгууллагын аль алинд АНУ хамгийн том багцыг эзэмшдэг тул хэлэлцэх гол асуудал нь тэдний талаар Трампын төлөвлөгөө байх болно.

буй нь АНУ-д үйлдвэрлэлийн ажлын байр устгахад хүргэсэн хэмээн буруутгажээ. Гэвч уг дүгнэлтийг няцаасан судалгаа ч гарсан байна. Жишээ нь, зарим эдийн засагч автоматизаци болон дотоод өрсөлдөөн ажлын байрны хомсдол гол буруутай гэж үзжээ. Трамп сонгогдсон

Цахим мэдээллийн үерт живээгүй сонин

Дэвид Бонд

Daily Telegraph бол ховорхон “амьтан”. Ашигтай ажилласаар байгаа Британийн цаасан сонин. Хэвлэмэл сурталчилгааны ашиг унаж, дижитал зар Facebook, Google рүү нүүж байгаа нь орчин үеийн мэдээллийн үйлдвэрлэлийн онцлог. Гэтэл Telegraph Media Group 2015 онд нийт 320 сая паундын эргэлтээс 48 сая паундын татварын өмнөх ашиг олсон нь 2014 оноос хоёр саяар өссөн үзүүлэлт юм. Одоо ч тус сонин Британийн хамгийн олон хувь хэвлэгддэг өдөр тутмын сонин хэвээр байна. Гэхдээ 2000 онд өдөртөө нэг сая хувиар хэвлэгддэг байсан оргил үеэс тоо нь буурч, хоёрдугаар сарын байдлаар 457331 хувь хэвлэгдсэнийг Аудитын товчооноос мэдээлэв.

Telegraph-ийн үйл ажиллагааны ахлах ажилтан Ник Хью “Бид ашигтай бизнес эрхэлж

байгаадаа маш бахархалтай байна. Тэрбээр Yahoo-ийн зараар уг ажилд орсон боловч 20 ажлын байр танах шийдвэр гаргасан аж. Ноён Хью цааш нь “Цахим түрэлт үргэлжилж буй орчинд шилжилтийн хугацаа гэж бараг байхгүй. Урагшлах, улмаар хурдлахаас өөр гаршгүй. Ажил асар их байгаа боловч би ирээдүйдээ өөдрөг байгаа. Бусад сонин хэвлэлтэй харьцуулахад бид азтай” хэмээн өгүүлэв.


Гэвч Telegraph-ийн брэндийг сайжруулахаар уригдсан Энди Коулсонд жилийн 200 мянган паундын цалин өгөхөөр зарлагдсан нь цомхотголтой давцаж, азгүй тохиолдол болжээ. Түүнчлэн 2014 онд бусдын утсыг хакердсан хэрэгт 18 сар хорих ял шийтгүүлсэн олон улсын мэдээний редакторыг буцаан томилсон нь зарим хүнд түгших сэтгэл төрүүлээ. Нэг захирал хэлэхдээ уг шийдвэрийг

ер бусын гэж нэрлээд “Сонины бизнес гурван жил тамд байсан. Гэтэл уг явдлын шалтгаан болсон хүн буцаад ирлээ” хэмээв.

Үнэхээр ч цахим бизнесээс ялгаатай нь хэвлэлийн ирээдүйн чиглэл тодорхойгүй, сонинд цомхотгол хийгдсэн зэргээс одоохондоо ашигтай ажиллаж байгаа ч Telegraph байнгын хямралд байна гэж зарим сэтгүүлч болон удирдлага дүгнэдэг. 1995-2005 оны хооронд Sunday Telegraph-ийн редактор байсан Доминик Лоусон “Хамгийн амжилттай сонин сэтгүүл зүйг яс махаараа ойлгодог эзэнтэй буюу агуу менежерүүдийг хөслөн ажиллуулдаг. Хэрэв бидэнд эдгээрийн аль нь ч байхгүй бол асуудалд орлоо гэсэн үг” гэжээ.

Зарим хүн байгууллагын дээд удирдлагын дунд хагарал гарсан, бизнесийг зарах гэж байгаа гэх мэт үг цухуйлгаж, ерөнхий захирал Мэрдок Макленнаныг

The Daily Telegraph



шүүмжлэх нь бий. Telegraph-ийн нэг захирал ярихдаа “Маргаан өмнөхөөс нэлээд хурцалсан. Эргэлтийн үе болж байгаа мэт санагдаж байна” гэв. 2004 онд сэр Дэвид, Фредерик Баркли

нар Daily Telegraph-ийг 665 сая паундаар худалдан авснаас хойш зургаан редакторын нүүр үзсэн юм. 2015 онд Макленнантай цахим төлөвлөгөөний талаар санал зөрсөн тул Жейсон Сейкен

хамгийн сүүлд халагдсан байна.

Сонинд дээгүүр алба хашиж байсан нэг хүн “Энд нэг жишиг бий. Эзэгн хөрөнгө оруулдаггүй. Тэд хямд зардлаар ажиллуулдаг. Ингээд золиосонд нь хэн нэгэн халагддаг” хэмээн шүүмжилжээ. Барклийнхэн сонинг авснаас хойш энд ажилладаг сэтгүүлчийн тоо 500-гаас 380 болтлоо цөөрсөн. Хүндэрсэн орчинд Telegraph зардлаа нөхөн ашигтай ажиллаж байгаа ч онлайн ирээдүйд амжилтад хүрэх аргаа олоогүй л байна. Макленнаныг залгамжилж магадгүй гэж үздэг ноён Хью Apple-тэй туншлэх нь амжилтын түлхүүр гэж үздэг. Telegraph сонин Apple News app-аар контентоо уншигчдад хүргэдэг 4000 орчим хэвлэлийн нэг бөгөөд уг сугваар Британид зар түгээх тусгай эрхийг эзэмшдэг аж.

Өнгөрсөн арваннэгдүгээр сард байгуулсан гэрээний дагуу Daily Telegraph вебсайтынхаа арын орон зайд өндөр үнэ тогтоосон бөгөөд энд сонинны контентын 20 хувь нь байрладаг юм. Ноён Хью ярихдаа Telegraph-ийн ирээдүй редакцийн эв нэгдэлд суурилдаг гээд ойрын хэдэн сардаа өөрчлөлт хийх бодолгүй байгаагаа мэдэгдсэн юм. **FT**

Японы хүн ам эрс цөөрөх сануулга



Робин Хардинг

Японы хүн ам 2065 онд 88 сая, 2115 онд 51 сая болтлоо цөөрнө гэж тус улсад хүн ам цөөрөх аюул нүүрлэж буйг

анхааруулсан судалгаанд дурджээ. Энэхүү таамаг нь тус улсын өнөөгийн 127 сая хүн ам тус бүр 31 ба 60 хувь буурна гэсэн тооцоо хэмээн Хүн ам,

нийгмийн аюулгүй байдлын үндэсний хүрээлэнгийн тайланд бичсэн байна. Уг хүрээлэн таван жил бүрт нэг удаа албан ёсны таамагаа нийтэлдэг аж. Дээрх тооноос үзэхэд Токио цагаачлалын бодлогоо өргөн хэмжээнд чөлөөлөхгүй бол 1960-аад оноос хойш төрөлт буурсны уршаар энд уналт нүүрлэж байгаа юм.

Гэхдээ хэтийн төлөв маш бүрхэг байгаа хэдий ч сүүлийн тайлангаас үзэхэд 30-аас дээш насны эмэгтэйчүүд нэмж хүүхэд төрүүлэх болсноор хүн амын тоо буурах хурдац саарч байгаа юм байна. Хүрээлэнгийн судлаачид “Үүний үр дүнд бид 2065 онд хүн амын таамгийг 81 сая биш, 88 сая болгож дээшлүүлсэн. Харин хүн амын тоо 100 саяас доош буух он 2048 биш 2053 болж цаашилсан” гэж бичжээ.

Түүнчлэн таван жилийн өмнө нэг эмэгтэйд ногдох нийт

төрөлтийн тоо 1.35 байсан бол одоо 1.44 болж дээшилсэн нааштай үзүүлэлт гарчээ. Нийт төрөлтийн тоо гэдэг нь нэг эмэгтэйн амьдралын туршдаа төрүүлэх хүүхдийн тоо юм. Хүн ам өөрөө нөхөн үржихэд хангалттай түвшин 2.1 байдаг. Хүрээлэнгийн тооцоогоор саяхнаас төрөлт нэмэгдсэн нь удаан үргэлжлэхгүй. Хэрэв Шинзо Абэгийн Засгийн газар хүүхдийн асаргаа сайжруулж, ажил, гэр бүлийг хослуулах боломжийг хөнгөвчлөх арга хэмжээ авч чадвал ирээдүйд хүн амын тоо дээшлэх боломж бий. Ноён Абэ нэг эмэгтэйн нийт төрөлтийн дунжийг 1.8-д хүргэх зорилт тавьсан билээ. Хэрэв энэ нь хэрэгжвэл судлаачдын тооцоолсноор Японы хүн ам 2065 онд 100 саяаас жаахан дээгүүр байх юм.

Гэхдээ уг тайлангийн гол

тооцооллоос үзэхэд 65-аас дээш насныхан одоо хүн амын 27.3 хувийг эзэлж байгаа бол 50 жилийн дараа 38.4 хувьд хүрэх ёстой. Үүний үр дүнд хүн амын эрүүл мэндийн үйлчилгээ, тэтгэврийн тогтолцоонд хүндрэл учирч магадгүй. Тус хүрээлэн Японд цагаачлан ирэгсдийн нийт тоо жилдээ 50 мянга орчим байгааг мэдээлэв. Токио гол төлөв оюутан сурагчид, зочин ажилчинд түр оршин суух зөвшөөрөл олгодог бөгөөд тэдний олонх нь тодорхой хугацааны дараа эх орондоо буцдаг.

Мөн хүрээлэнгийн төсөөлөл тооцоогоор Япон улс хүн амын тоогоо одоогийн түвшинд тогтоон барихын тулд нэг жилд цагаачлан ирэх хүмүүсийн тоог 500 мянгаас дээш гаргах шаардлагатай гэж үзсэн байна. **FT**

Эдийн засаг

МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Сэргэлт заасан эхний онош



С.Батсайхан / ЗГМФ

Гадаад худалдааны ашиг өнгөрсөн улиралд хоёр дахин өссөн байна

Г.Байгал
@baigalZGM

Монголын эдийн засгийн эхний улирлын онош тодорч эхэллээ. Тоон дүн, статистик мэдээллээс үзвэл сөхөрсөн эдийн засагт сэргэх шинж ажиглагджээ. Монголчуудын мөнгөний гол эх үүсвэр болох худалдаанаас гэхэд л хагас тэрбум ам.долларын ашиг олсон байна. Экспорт, импортыг

дэнсэлбэл, гадаад худалдааны ашиг хоёр дахин өслөө. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр худалдааны тэнцэл энэ оны эхний гурван сард 523.7 сая ам.доллартай тэнцжээ.

Монгол Улс түүхий эдээ борлуулж, оронд нь өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн хилийн чанадаас худалдан авдаг. Тэгвэл бидний хилийн чанадад нийлүүлсэн барааны дүн бараг 40 хувиар өссөн байх юм. Экспорт ийн тэлэхэд нүүрс дагасан орлого үлэмж хэмжээгээр нөлөөлсөн. Өнгөрсөн гурван сард нүүрснээс олсон экспортын орлого 450 орчим сая ам.доллараар өссөн нь онцолж болох үзүүлэлт. Хар алт Монголд ногоон жим татуулжээ.

Экспорттой зэрэгцээд импорт ч ахисан. Бидний хилийн чанадаас худалдан авсан ба-

рааны хэмжээ 30 орчим хувиар дээшилжээ. Хэдийгээр импорт өссөн ч худалдаанаас хүртэх монголчуудын ашиг ахиу байсан нь эдийн засагт тохиож буй гэгээтэй мэдээний нэг.

Тэгвэл мөнгөний “барометр” инфляцийн түвшин өсөлтийн зүг зааж байна. Хэрэглээний үнийн индекс өмнөх сард хоёрдугаар сараас 0.9 хувиар өссөн. Харин жилийн дүнгээр 2.5 хувиар дээшилжээ. Эдийн засгийн “луужин” инфляцийн түвшин оны эхнээс 3.1 хувьд хүрсэн нь өмнөх хоёр жилийн дунджаас 1.2-1.4 нэгж хувиар эрчимжсэн дүн. Үүнд хүнс, усны бүлгийн үнэ 9.7 хувиар өссөн нь

нөлөөлөв. Ялангуяа, мах, махан бүтээгдэхүүний үнэ 26.9 хувиар чангарчээ.

» Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ сарын дүнгээр 0.2 хувиар доошилсон байна.

» Хэрэглээний үнэ ийн яльгүй эрчимжсэн бол үйлдвэрлэгчийн үнэ буурчээ.

» Бидний хилийн чанадаас худалдан авсан барааны хэмжээ 30 орчим хувиар дээшилжээ.

Өнгөрсөн сард хэрэглээний үнэ Дорнод, Говь-Алтай аймагт 0.1-0.3 хувиар буурсан бол Дархан-Уул аймагт өөрчлөлтгүй, Улаанбаатарт болон бусад 18 аймагт 0.1-2.5 хувиар дээшилжээ.

Хэрэглээний үнэ ийн яльгүй эрчимжсэн бол үйлдвэрлэгчийн үнэ буурлаа. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ сарын дүнгээр 0.2 хувиар доошилсон байна. Харин жилийн өмнөхтэй харьцуулбал, 70 хувиар өсчихөөд байгаа аж. Монголын Үндэсний статистикийн хорооноос гуравдугаар сарын Монголын нийгэм, эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг эхнээс нь танилцуулаад байна. [ЗГМ]

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

48 компани энэ сард хувьцаа эзэмшигчдийн хурал хийнэ

М.Дэлгэрмаа
Шинжээч

Хөрөнгийн биржид бүртгэлтэй 48 компани энэ сард хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийх гэж байна. Ингэснээр хувьцаат компаниудын 61 хувь буюу 134 аж ахуйн нэгж 2017 онд багтаж хуулийн хугацаандаа хувь нийлүүлэгчдийн хурлаа хийх аж. Энэ тоо өмнөх онд 63 хувьтай байжээ. Сүүлийн дөрвөн жилийн хугацаанд компаниудын 60 гаруй хувь нь тогтмол хувьцаа эзэмшигчдийн хурлаа зарлаж байгаа.

Компаниуд хурлаараа өнгөрсөн оны бизнес болон санхүүгийн тайлангаа хэлэлцэж, шинэ онд хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөгөө баталдаг. Тухайлбал, зах зээлийн үнэлгээгээр тэргүүдэгч АПУ компани

2016 онд 18.6 сая ам.долларын зээл болон хүүгийн төлбөр төлсөн бол энэ онд 16 сая ам.долларын зээл төлөхөөр төлөвлөжээ.

Харин уул уурхайн салбарын “Шивээ Овоо” компани энэ оны худалдан авалтын төлөвлөгөөгөө баталж, 26.1 тэрбум төгрөгийг сэлбэг, түлш шатахуун, бусад бараа, үйлчилгээнд зарцуулахаар болжээ. Энэ нь өмнөх оныхоос 2.5 дахин буурсан дүн. Худалдан авалтын бүтцийг харвал түлшинд 8.51 тэрбум төгрөг буюу нийт үнийн дүнгийн 35.9 хувийг зарцуулах аж. Жижиг компаниудаас “Дархан хөвөн” компани хувьцаа эзэмшигчдийн хурлаараа компанийн үйл ажиллагааг сэргээх талаар бизнес төсөл хэрэгжүүлэхээр болсон. Үүнээс гадна одоогоор 18 хувьцаат компани ногдол ашиг хуваарилах гэж байна.

дэлхийд

Их өр Азид сорилт дагууллаа

Н.Алтан
Шинжээч

Азийн санхүүгийн их хямралаас хойш 20 орчим жил өнгөрсөн ч бүс нутгийн өрийн хэмжээ өнөөг хүртэл сорилт хэвээр байгааг судлаачид онцолж байна. Азийн хамгийн том эдийн засаг болох БНХАУ-ын өр гэхэд тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 258 хувьтай тэнцэж байгаа аж. Мөн БНСУ, Австралийн өрхийн зээл түүхэн дээд түвшиндээ хүрч өсчээ. Хувийн хэвшил болон Засгийн газрын өр нэмэгдсэнээр үл хөдлөх хөрөнгө зэрэг зарим зах зээлд хөөсрөл үүсэж эхлээд

байгаа аж.

Үлэмж хэмжээний өртэй зэрэгцээд Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ өсгөх нь Азийн улс орнуудад өрийн дарамтыг нэмэгдүүлэх сөрөг талтай байгаа ажээ. АНУ-ын Төв банк бодлогын хүүгээ нэмэгдүүлэх нь Азийн улсуудын зээлийн өртгийг нэмэгдүүлнэ. Түүнчлэн 2021 онд эргэн төлөлт нь эхлэх нэг их наяд ам.долларын үнэлгээ бүхий фондын 63 хувь нь ам.долларынх байгаа аж. Гэхдээ Япон болон Европын орнууд мөнгөний тэлэх бодлого баримталж буй нь АНУ-ын эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулна гэж шинжээчид дүгнэж байна.

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

СЭТГҮҮЛЧ:

Ажлын байрны үндсэн зорилго: Мэдээний шууд болон шууд бус хөтөлбөрүүдэд мэдээ сурвалжилга бэлтгэж нийлүүлэх, хөтөлбөрт мэдээ танилцуулах, мэдээний болон техникийн ажилтнуудтай багаар хамтран ажиллах.

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:

- Эдийн засаг, бизнесийн тодорхой салбарыг хариуцан ажиллаж, мэдээ сурвалжилга бэлтгэх
- Салбарын бизнес, зах зээлийн судалгаа хийх, биржид бүртгэлтэй компаниудын тайлан, гол үзүүлэлтүүдэд анализ хийх, төлөв таамаг бэлтгэж танилцуулах
- Шууд болон шууд бус хөтөлбөрт мэдээ, сурвалжилга танилцуулах, зочидтой ярилцах, яриа авах

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Сэтгүүл зүй, хэл шинжлэлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн
- Олон улсын харилцаа, бизнес, санхүү, эдийн засгийн чиглэлээр дээд боловсрол эзэмшиж, зах зээлтэй холбоотой аль нэг салбарт ажиллаж байсан, эсвэл зохих ойлголт, мэдлэгтэй бол давуу тал болно
- Монгол хэлний яриа, бичгийн дүрмийн мэдлэг, найруулан бичих чадвар шаардсан ажил хийх туршлагатай
- Мэргэжлийн ёс зүйтэй
- Мэдээллийн цуглуулах, судалгаа шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай.

ОРЧУУЛАГЧ:

Ажлын байрны үндсэн зорилго: Мэдээний шууд болон шууд бус хөтөлбөрүүдэд гадаад мэдээ сурвалжилгыг орчуулан бэлтгэж нийлүүлэх, шууд хөтөлбөрт гадаад мэдээний синхрон орчуулга хийх, гадаад нэвтрүүлгийн орчуулга хийх, бүтээлийн багуудтай хамтран ажиллах.

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:

- Олон улсын харилцаа, эдийн засаг, улс төр, бизнесийн салбарын мэдээлэл орчуулах
- Дээрх сэдвээр шууд болон шууд бус хөтөлбөрт орчуулга хийх,
- Олон улсын сүлжээ, агентлагуудаас хүлээн авсан мэдээ сурвалжилга, ярилцлагыг орчуулах, дуу оруулах

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Англи хэлний орчуулагчийн бакалавраас доошгүй зэрэгтэй (орос хэлтэй бол давуу тал болно)
- Эдийн засаг, бизнесийн салбар, танин мэдэхүйн нэвтрүүлгийн орчуулга хийх бүрэн чадвар, туршлагатай (аман болон бичгийн орчуулга хийж байсан туршлагатай бол давуу тал болно)
- Англи, монгол хэлний яриа, бичгийн дүрмийн мэдлэг, найруулан бичих чадвар шаардсан ажилд туршлагатай
- Эдийн засгийн аль нэг салбар, зах зээлтэй холбоотой ажил хийж байсан, эсвэл зохих ойлголт, мэдлэгтэй бол давуу тал болно.

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай
- Телевизийн салбарт удаан хугацаанд тогтвортой ажиллах хүсэл эрмэлзэлтэй
- Бусадтай харилцах, өөрийгөө зөв илэрхийлэх ур чадвартай
- Интернэтийн орчинд ажиллах, компьютер ашиглах мэдлэгтэй, программ дээр ажиллах чадвартай
- Багаар болон бие даан ажиллах, манлайлах, ажлын ачаалал даах чадвартай байх.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:

- Ажилд орохыг хүссэн өргөдөл, анкет
- Гурван үеийн намтар
- Ерөнхий боловсролын гэрчилгээ, их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн үнэмлэхийн хуулбарыг нотариатаар батлуулсан байх
- 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын дотор авахуулсан)
- Оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

Анкетыг “BLOOMBERG TV MONGOLIA” телевизийн байранд ирж бөглөх бөгөөд бүрдүүлэх материалыг хүлээлгэн өгнө үү.

Хаяг: Блю Скай тауэр, 4 давхар, № 403, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14240, Монгол Улс, Холбоо барих утас: 70102020

ЗГМ ТОВЧХОН

» ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

72.2

Хувь. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн ажил хайгч иргэд энэ оны гуравдугаар сарын эцэст 47.6 мянга байгаагаас 72.2 хувь буюу 34.4 мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар буурсан бол хоёрдугаар сартай харьцуулахад 0.9 хувиар өсчээ.

» ХӨДӨӨ АЖ АХУЙ

100

Мянга. Ямааны нэг килограмм ноолуурын үнэ Дорнод аймагт 100 мянган төгрөгт хүрчээ.

» БАНК САНХҮҮ

106

Тэрбум төгрөг. Хугацаа хэтэрсэн зээл хоёрдугаар сард 1.052 их наяд төгрөгт хүрч, сарын дүнгээр 106 тэрбум төгрөгөөр дээшилжээ.

» ТҮҮХИЙ ЭД

1.6

Хувь. Brent төрлийн газрын тосны ханш 0.2 хувиар өсөж, 52.98 ам.доллартай тэнцлээ. Тус түүхий эд даваа гарагт 1.6 хувиар чангарсан юм.

0.2

Хувь. Алтны ханш гурван өдөр дараалан өсөөд байна. Олон улсын зах зээлд унци алтны үнэ 1257.22 ам.долларт хэлбэлзэж байна.

» ҮНЭТ ЦААС

3.9

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар хоёрдугаар сард 23 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 3.9 дахин өсчээ.

» ХӨРШ

870

Сая ам.доллар. БНХАУ-ын Төрийн өмчит “PetroChina” компани энэ оны нэгдүгээр улиралд 870 сая ам.долларын цэвэр ашиг олсон байна. Өнгөрсөн оны мөн үед тус компани 13.8 тэрбум юанийн алдагдал хүлээжээ.

4

БНХАУ-ын томоохон дөрвөн банкны нийт ажилтны тоо өнгөрсөн онд сүүлийн зургаан жилийн хугацаанд анх удаа буурчээ.

» ДЭЛХИЙ

10000

“Wells Fargo” банк мянган ажилтнаа буцаан ажилд авахаар болжээ. Тус компани ажилчдаа хэт өндөр үнийн дүнтэй борлуулалт хийхийг шаардаж, зорилтыг нь хангаагүй тохиолдолд ажлаас нь чөлөөлдөг байжээ.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2419.66
Евро	2632.54
Япон иен	21.89
ОХУ рубль	42.54
БНХАУ юань	350.56
БНСУ вон	2.11

Эдийн засаг

Ямар зардлыг танах эсэх нь Засгийн газрын өөрийнх нь асуудал

БАЙР СУУРЬ

Хөгжиж буй орны эдийн засаг удаан хугацаанд тогтмол өсөх нь чухал

Б.Мөнх
ЗГМ

Олон улсын валютын сангийн Монгол Улс дахь суурин төлөөлөгч Нийл Сакертай ярилцлаа. “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлбэл зээлийн хүү буурна хэмээн тэрбээр тодотгов.

–Монгол Улс ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдахын тулд улсын төсвөө тодотгох ёстой. Хэрэв хугацаандаа амжихгүй бол Монгол Улс энэ хөтөлбөрт хамрагдах, эсэх нь эргэлзээтэй болох уу?

–Монгол Улсын Засгийн газартай харилцан тохиролцсон урьдчилсан нөхцөлүүдийн нэг нь энэ оны төсөвт тодотгол хийж, УИХ-аар батлуулах юм. “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжүүлэх Монгол Улсын хүсэлтийг ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн хурлаар оруулж, хэлэлцүүлэхээс өмнө энэ нөхцөлийг биелүүлж, төсвөө тодотгох ёстой гэсэн үг. Тиймээс үүнийг ойрын хугацаанд хийх шаардлагатай. Хаврын чуулганы үеэр хэлэлцэх асуудлын хамгийн эхнийх нь энэ. Энэ долоо хоногт буюу дөрөвдүгээр сарын 14, 15-нд төсвийн тодотголыг батална гэсэн мэдээлэл бий. ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн хуралдааныг энэ сарын 28-нд

товлосон. Тиймээс цаг хугацааны хувьд амжина.

–Төв банк мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж байгаа. Энэ бодлогоо хэвээр хадгалахыг ОУВС зөвлөсөн. Хэр удаан үргэлжлэх бол?

–Монгол Улсын өнөөгийн зээлийн хүүгийн түвшин маш өндөр байгаа. Төгрөгөөр олгож буй зээлийн хүү дунджаар 25-30 хувь. Ийм орчинд бизнес ашигтай байх боломжгүй. Өнгөрсөн хугацаанд бодлогын алдаа гаргаж, хүүгийн бүтэц буруу болсонтой энэ нь шууд холбоотой. Тухайлбал, ам.долларын хадгаламжийн хүү Монголд найман хувь байгаа. Харин АНУ-д нэг хувь. Тухайн орны эрсдэл өндөр байгаагаас хүү нь дагаж өссөн гэсэн үг. Засгийн газар ОУВС-тай тохирсон хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлж чадвал цаашид Монгол Улсын эрсдэл буурах боломж бүрдэнэ. Үүнийг дагаад хүүгийн бүтэц сайжирна. Мөн Засгийн газар их хэмжээний зээл авах шаардлага нь багасах юм. Зээлийн эрэлт багасахаар Засгийн газрын үнэт цаасны хүүгийн түвшин доошилно. Ингэснээр гадаадынхан Монгол Улсад төгрөгөөр хөрөнгө оруулалт хийх сонирхол нь нэмэгдэнэ. Тиймээс энэ хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлбэл хүү цаашид буурна гэдэгт итгэлтэй байна.

–Төсвийн тодотголд зарим татвар нэмэхээр тусгасан. Энэ нь хувийн хэвшлийнхэнд хэрхэн нөлөөлөх вэ?

–Эдийн засгийн зөв бодлого хэрэгжүүлж эхэлснээр хөрөнгө оруулалт сэргэнэ хэмээн хүлээж байгаа. Ингэснээр хүүгийн ерөнхий түвшин буурна. Үүнийг дагаад хадгаламж болон зээлийн хүү багасна. Одоогоор хадгаламж болон зээлийн

хүүгийн зөрүү их байгаа. Энэ нь банкны үйл ажиллагаа, бүтэц оновчгүйн илрэл юм. Тиймээс банкуудын балансыг сайжруулах арга хэмжээ авна. Үр дүнд нь зээлийн хүү буурна. Татварын тухайд өндөр орлоготой иргэдэд ногдох хэмжээ нь өснө гэж харж байгаа. Бага орлоготой иргэдэд энэ нь нөлөөлөхгүй. Монгол Улсад татвар ногдох хувь хэмжээ дэлхийн бусад орныхтой харьцуулахад бага учраас нэмэгдүүлэх орон зай бий гэж бодож байна. Мөн НӨАТ-ыг нэмэгдүүлээгүй гэдгийг онцлон тэмдэглэе. Ер нь өндөр орлоготой хүмүүсээс ахиу татвар авах зарчим баримталж байгаа.

Захирлуудын зөвлөлийн хуралдааныг энэ сарын 28-нд товлосон

–“Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхийн тулд ипотекийн зээлийн санхүүжилтийг зогсоосон гэсэн мэдээлэл бий. Монголбанк санхүүжилтээ Засгийн газарт хэзээ шилжүүлэх вэ. Энэ талаар юу гэж тохиролцсон бэ?

–Засгийн газар төсвийн зардлаа багасгах шаардлагатай байгаа шүү дээ. Харин ямар зардлыг танах эсэх нь Засгийн газрын өөрийнх нь шийдэх асуудал. Хэрэв ипотекийн зээлийн хөтөлбөрийг цааш үргэлжлүүлэх шаардлагатай гэж шийдвэрлэвэл бид хүлээн зөвшөөрж, дэмжинэ. Гэр хороо-



Б.Ганбаяр / ЗГМ

лолд маш олон хүн амьдарч байна. Өвлийн улиралд утаа ихэсдэг зэрэг олон асуудал бий. Тиймээс орон сууцны зээлийн хөтөлбөрийг цаашид хэрэгжүүлэх хэрэгтэй. Гэхдээ төв банк энэ хөтөлбөрийг санхүүжүүлэх нь буруу. Харин Засгийн газар цаашид хариуцаж, санхүүжилтийг нь төсөвтөө тусгах нь зүйтэй. Хөтөлбөрийн хүрээнд төсвийн алдагдлыг багасгах зорилт тавьсан учир энэ хэмжээндээ багтаан Засгийн газар ипотекийн зээлийн хөтөлбөрийг санхүүжүүлэх боломжтой. Харин төв банк үүнд оролцохгүй байх хэрэгтэй. Учир нь төв банкны эрхлэх үйл ажиллагааны


хүрээнд энэ нь хамаардаггүй. Ипотекийг Засгийн газарт шууд шилжүүлэхэд зарим асуудал байсан. Одоогоор энэ хөтөлбөрийг хүүгийн төлбөрөөр санхүүжүүлж буй. Тэгэхээр одоо байгаа мөргөлийн зээлийн үлдэгдэл нь ойрын хугацаанд өсөхгүй гэсэн үг. Монголбанк энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж байхад зээлийн хэмжээ хяналтгүйгээр өссөн. Тэр хэрээр Монголбанкинд дарамт учирсан тул хяналт хэрэгтэй. Ер нь санхүүжилтийн хэмжээ одоогийн түвшинд байна гэж ойлгож болно.

–Үүнээс гадна арилжааны банкуудын “эрүүл мэнд”-д онцгой анхаарсан шүү дээ.

Тухайлбал, банк бүрт үнэлгээ хийнэ гэсэн. Үүнийг хөндлөнгийн байгууллагаар хийлгэнэ гэдэг нь ямар учиртай вэ?

–Арилжааны банкууд зээлээ танаж эхэлсэн. Балансынхаа бараг тал хувийг бэлэн мөнгө хэлбэрээр байршуулсан. Мөн сул чөлөөтэй дийлэнх эх үүсвэрээрээ Засгийн газрын үнэт цаас худалдан авч, төсвийн алдагдлыг санхүүжүүлэн, өндөр өгөөж хүртээд сууж байна. Уг нь эдийн засаг хүндэрсэн үед арилжааны банк хувийн хэвшлийнхнийг санхүүгийн эх үүсвэрээр хангах ёстой. Гэтэл энэ үүргээ гүйцэтгэж чадахгүй байна. Үүнтэй зэрэгцээд чанаргүй зээлийн хэмжээ сүүлийн үед огцом өссөн. Тиймээс үйл ажиллагааг нь бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авахаас өмнө банкны системд тулгарсан ямар асуудал байгааг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэх юм. Хөндлөнгийн байгууллага нь бидэнтэй харилцан тохиролцсон, нэгдсэн аргачлалаар үнэлгээ хийнэ. “Онош”-ыг нь тогтоосны дараа ямар эмчилгээ хийх нь тодорхой болох юм. Өөрөөр хэлбэл, банкуудын үйл ажиллагааг бэхжүүлэхэд хэдий хэмжээний хөрөнгө шаардлагатай нь тодорхой болно. Үүний дараа хувь нийлүүлэгчид нь шаардлагатай байгаа нэмэлт эх үүсвэрийг гаргах ёстой болно. Ингэснээр арилжааны банк санхүүгийн хувьд бэхжиж, эдийн засгаа тэтгэх зээл, санхүүжилт гаргах боломж нь нээгдэнэ. Зээлийн хүү ч гэсэн буурах ёстой. Хөгжиж буй орны хувьд эдийн засаг нь удаан хугацаанд тогтмол өсөх нь чухал. Ази тивийн улс орнуудын эдийн засаг жилд дунджаар найман хувь өсөж байна. [ЗГМ]

Төгрөг чангарч, ам.доллар сулрав



Төв банкнаас зарласан төгрөгтэй харьцах ам.долларын албан ханш сүүлийн нэг сард

Төв банкнаас зарласан ам.долларын албан ханш 2419.66 төгрөгт хүрэв. Энэ нь даваа гарагаас сөн төгрөгөөр буурсан дүн болж байгаа юм. Он гарснаас хойш төгрөгтэй харьцах ам.долларын ханш гуравдугаар сарын 23-наас эхлэн тасралтгүй чангарч, улмаар өнгөрсөн гурван сарын хугацаанд ам.долларын

төгрөгтэй харьцах ханш 70 төгрөгөөр буурчээ. Ам.долларын ханшийн хөдөлгөөнтэй харьцуулахад юанийн албан ханшид огцом өөрчлөлт ажиглагдаагүй ч төгрөгийн эсрэг тасралтгүй суларсан хэвээр байна. Мянгар гарагт юанийн нэгжийн ханш 357.39 төгрөгт хүрсэн нь энэ оны хамгийн доод түвшинд тооцогдож байгаа юм. [ЗГМ]

Засгийн газрын МЭДЭЭ

ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	62.03	▲ +1.96%	4/11/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.034	▼ -5.88%	4/11/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	28.25	▲ +3.62%	4/11/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.022	▼ -8.33%	4/11/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	4/11/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.8	▲ +2.7%	4/11/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.06	▼ -0.25%	4/11/2017
SOUTHGOLD RESOURCES	SGQ	TSX	CAD	0.4	▲ +9.59%	4/11/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.21	▼ -6.67%	4/11/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.68	▼ -2.86%	4/11/2017

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1257.62	▲ +0.32%	4/11/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	946.8	▲ +0.72%	4/11/2017
МӨНГӨ	SIA	унци	17.94	▲ +0.14%	4/11/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	260.35	▼ -0.02%	4/11/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	75.28	▼ -2.12%	4/11/2017
WTI ТОС	CLA	баррель	53.1	▲ +0.04%	4/11/2017
БРЕНТ	COA	баррель	56.04	▲ +0.11%	4/11/2017
БЕНЗИН	XBA		175.85	▲ +0.02%	4/11/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mtmbt	3.257	▲ +0.59%	4/11/2017
НҮҮРС (NYMEX)	OZA	тонн	336.55	▲ +0.21%	4/11/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	83.75	▼ -0.77%	4/11/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.165	▼ -0.36%	4/11/2017
БУДАА	RRA	центнер	10.2	▼ -0.63%	4/11/2017
БУУДАЙ	WA	бушель	428.25	▼ -0.12%	4/11/2017
КАКАО	CCA	тонн	1964	▼ -2.14%	4/11/2017
КОФЕ	KCA	фунт	1.421	▼ -0.18%	4/11/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.

Тэнцвэртэй мэдээллийг Танд

WORLD
FT
The New York Times

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	340.97	▲ 0.05%	4/11/2017
ГОВЬ ХК	GOV	13070	▲ 3.98%	4/11/2017
МИК ХОЛДИНГ ХК	MIK	10010	▼ -3.38%	4/11/2017
МАХ ИМПЕКС ХК	MMX	2450	◀ 0%	4/11/2017
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	22500	▼ -2.17%	4/11/2017
АДУУН ЧУЛУУН ХК	ADL	2568	▲ 7.94%	4/11/2017
БАГАНУУР ХК	BAN	1650	◀ 0%	4/11/2017
БИ ДИ СЕК ХК	BDS	1340	◀ 0%	4/11/2017
ГУТАЛ ХК	GTL	14610	▲ 2.53%	4/11/2017
ХВХ ГАН ХК	HGN	55	◀ 0%	4/11/2017
ЖЕНКО ТҮР БҮРО ХК	JTB	56.46	▲ 2.56%	4/11/2017
МАТЕРИАЛИМПЕКС ХК	MIE	8500	◀ 0%	4/11/2017
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	394.23	▲ 1.08%	4/11/2017
ОЛЛОО ХК	OLL	75	▲ 0%	4/11/2017
РЕМИКОН ХК	RMC	45.07	▼ -2.02%	4/11/2017
ШАРЫН ГОЛ ХК	SHG	2300	◀ 0%	4/11/2017
ШИВЭЭ ОВОО ХК	SHV	2217	▲ 0.54%	4/11/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5880.926	+3.11	▲ +0.05%
DAX INDEX	DAX	12177.83	-22.69	▼ -0.19%
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15730.79	+63.66	▲ +0.41%
S&P ASX 200	AS51	5929.274	+16.39	▲ +0.28%
S&P 500	INX	2357.16	+1.62	▲ +0.07%
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3288.966	+19.57	▲ +0.6%
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	20658.02	+1.92	▲ +0.01%
TOP 20	MSETOP	13149.21	+245.21	▲ +1.9%
FTSE 100	UKX	7384.31	+35.37	▲ +0.48%
HANG SENG	HSI	24088.46	-173.72	▼ -0.72%
NIKKEI 225	NKY	18747.87	-50.01	▼ -0.27%